

Орос хэлнээс зохиогчийн зөвшөөрлөөр  
орчуулсан Б. Эрдэнэбилэг

**Contacts:**

**Valentin Krasnogorov:**

Tel.; (7)-951-689-3-689 (972) 53-527-4146,

(972) 53-527-4142

e-mail: [valentin.krasnogorov@gmail.com](mailto:valentin.krasnogorov@gmail.com)

<http://krasnogorov.com/english/>

**В.Красногоров**

**ХУВЬ ЗАЯАНЫ ХҮЛЭЭС**

“У КАЖДОГО СВОЯ ЗВЕЗДА”

**ДҮРҮҮД :**

**Эрэгтэй**

**Эмэгтэй**

**1 дүгээр үзэгдэл.**

*Нэгэн томоохон хотын захад байх хуучивтар хувийн байшингийн гал зуухны өрөө. Энгийн боловч чанартай тавилга тавьжээ. Хувцасны мөртэй өлгүүрүүдэд нилээд хэдэн хурц, мод өнгийн эрэгтэй цамц өлгөөтэй байна. Өрөөн доторх тухтай байдлыг гаднаас сонсогдох цаг агаарын тааламжгүй чимээ тодотгож өгнө. Эмэгтэй ганцаараа, мод хөрөөдөж сууна. Эрэгтэй орж ирнэ. Нойтон цувнаас нь ус дусна.*

**Эрэгтэй.** Оройн мэнд!

**Эмэгтэй.** Оройн мэнд! (*Ажлаа үргэлжлүүлэнэ*)

**Эрэгтэй.** Тэнгэр ч айхтар байна шүү! Хотын төвөөс ирэхэд хэр удаг юм? Энд ч хот гэхээс илүү тосгон л гэхээр юм. Автобус хүлээж хагас цаг боллоо.

**Эмэгтэй.** Энд амьдрах надад сайхан байдаг юм.

**Эрэгтэй.** Чийгтэй, хүйтэн байна ... жаахан балгачихмаар байх чинь.

**Эмэгтэй.** Тэгээд хэн саад болоод байна?

**Эрэгтэй.** Орой болчихоод бүх газар хаачихаж, тэгээд хэнтэйгээ ч уух билээ... Ингэхэд танд арай ганц юм байгаа юм биш биз?

**Эмэгтэй.** Байхгүй.

**Эрэгтэй.** Ядаж жаахан ч болтугай?

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** Бүхэл бүтэн айлд дусал ч юм байхгүй гэж үү?

**Эмэгтэй.** Таныхаар би уудаг байх нь уу?

**Эрэгтэй.** Үгүй ядахнаа, зочинд зориулсан юм...

**Эмэгтэй.** Та надад саад болоод байна.

**Эрэгтэй.** (*Санаа алдан*) Уучлаарай.

*Эрэгтэй өрөөрүүгээ ороод буцаж ирнэ. Эмэгтэй түүн рүү асуусан, хүйтэн харна.*

Өрөөнд айхтар хүйтэн байна шүү.

**Эмэгтэй.** Халаагуураа залга л даа.

**Эрэгтэй.** Та зөвшөөрч байгаа юм уу?

**Эмэгтэй.** Тэгэлгүй яахав.

**Эрэгтэй.** Гялайлаа (*Өрөө рүүгээ хэд алхаснаа*) Та юу хөрөөдөж байгаа юм?

**Эмэгтэй.** Вандан сандлын хөл хийж байна.

**Эрэгтэй.** Танд туслах уу?

**Эмэгтэй.** Хэрэггүй.

*Эрэгтэй өрөөндөө орно. Эмэгтэй хөрөөдөхөө больж бялууны зуурмаг бэлдэж эхэлнэ. Эрэгтэй хоёр том туухай барьсаар орж ирнэ.*

**Эрэгтэй.** Өрөө халтал би энд жаахан дулаацаж болох уу?

**Эмэгтэй.** Тэг тэг, харин чимээгүй л байж үзээрэй.

**Эрэгтэй.** Тэр тэгэлгүй яахав.

*Эрэгтэй янз бүрийн сонин байрлалаар зогсож туухайгаар дасгал хийнэ. Эмэгтэй түүний чийрэг биеийг огтхон ч анзаарахгүй. Эрэгтэй тэвчээрээ барж Оройн хоол хийж байгаа юм уу?*

**Эмэгтэй.** Үгүй, би ийм орой юм иддэггүй.

**Эрэгтэй.** Тэгээд та чинь юу бэлдээд байгаа юм.

**Эмэгтэй.** Бялуу.

**Эрэгтэй.** (*Гонсгордуухан*) Маргааш идэх гэж үү?

**Эмэгтэй.** Тийм, маргааш.

**Эрэгтэй.** Зочид ирэх юм уу?

**Эмэгтэй.** Сонсооч, бид анхны өдөр л тохирсон шиг санагдах юм...

**Эрэгтэй.** (*Цагаахнаар*) Юун тухай?

**Эмэгтэй.** Та элдвийн юм яриад, шалгаагаад байхгүй гэж, тийм үү?

**Эрэгтэй.** Тийм л дээ, гэхдээ...

**Эмэгтэй.** Тийм үү гэж би асууж байна.

**Эрэгтэй.** (*Бууж өгөн*) Тийм л дээ.

**Эмэгтэй.** Тэгвэл та дуугуй байж үз, үгүй бол бид салах хэрэг гарах нь, өрөөндөө очсон чинь дээр байх! Өдийд дулаан болчихоо биз.

*Эрэгтэй уруу царайлан туухайгаа аваад өрөө рүүгээ явж байснаа*

**Эрэгтэй.** Ганц юм асуучих уу?

**Эмэгтэй.** Юун тухай гэдгээс л болно доо.

**Эрэгтэй.** Гэрээний нөхцлийн талаар.

**Эмэгтэй.** Энэ тухай бид бүгдийг ярилцаагүй гэж үү?

**Эрэгтэй.** Тийм л дээ... гэхдээ бага зэрэг нэмэлт оруулмаар байна. Та оройн хоолоо эрт идчихдэг юм байна... гэтэл би урлагийн хүн байж байдаг.

**Эмэгтэй.** Тэгээд юу гэж?

**Эрэгтэй.** Тоглолт орой тардаг болохоор оройн хоол оройтчихоод байдаг юм, буфетны хатсан хачиртай талхыг ямар хоол гэх вэ дээ.

**Эмэгтэй.** Өөрөөр хэлбэл та чинь манайд хоол идмээр байгаа хэрэг үү?

**Эрэгтэй.** Яг тийм. Таны гал тогооны үнэр намайг гурван өдөр галзууруулах нь. Харин урьдчилан сануулахад энэ том бие бас мэргэжлийн онцлогоос хамаарч би их иддэг хүн шүү. Ойлгож байгаа биз дээ.

**Эмэгтэй.** Тэгээд та хэдийг төлөх юм?

**Эрэгтэй.** Таны хэлснийг л төлье. Би саятан биш л дээ, гэхдээ ийм юман дээр наймаалцаад байдаг хүн биш шүү.

**Эмэгтэй.** (*Бодолхийлснээ*) За яахав, надад мөнгө хэрэгтэй.

**Эрэгтэй.** (Илтэд сэргэж) За сайн байна. Тэгэхлээр шууд эхлье. (*Ширээний ард сууна*)

**Эмэгтэй.** Шууд бүтэхгүй байх аа. Янз бүрийн хоолны үлдэгдэл идэхийг хүсэхгүй л биз дээ.

**Эрэгтэй.** Иднэ ээ.

**Эмэгтэй.** (*Хөргөгч онгойлгон бодно*) Чанасан мах байна, гахайн утсан мах байна, альныг нь идэх вэ?

**Эрэгтэй.** Аль альныг нь. Бас нөгөө юунаас дусал ч байдаг болоосой ... та ойлгож байгаа биз дээ. Энэ хараал идсэн хүйтэнд...

**Эмэгтэй.** За яахав, нэрмэл л байна.

**Эрэгтэй.** (*Ихэд баярлан*) Тэрнээс чинь илүү зүйл гэж юу байх вэ!

*Эмэгтэй тавагтай мах, лонх, хундага ширээн дээр өрнө.*

Гялайлаа, та мэдээж ханьсана биз дээ?

**Эмэгтэй.** Яалаа гэж, үгүй.

**Эрэгтэй.** За яахав, таны эрүүл энхийн төлөө! (*Ууна*) Гайхамшигтай! Таны гарын эд үү?

**Эмэгтэй.** Тийм.

**Эрэгтэй.** Тэгвэл дахиад таны төлөө!

*Эрэгтэй дахин 1 хундага уугаад хоолруу дайрна. Эмэгтэй гал дээр ямар нэг юм хийнэ. Эрэгтэй үргэлжлүүлэн идэж хоёр ч хундага ууна.*

Тэгэхлээр та чинь циркд ухаангүй дуртай юм биз дээ?

**Эмэгтэй.** Циркд үү? Энэ тухай би юу ч дуугараагүй санагдах юм.

**Эрэгтэй.** Дургүй хүн ч байдаггүй байх аа. Сайхан бие галбир, эр зориг, авъяас чадвар, баяр баясгалан. Цирк гэдэг чинь энэ дээ... за тэгэхлээр ганц хундага уугаач.

**Эмэгтэй.** Үгүй ээ.

**Эрэгтэй.** За яахав, тэгвэл таны төлөө уухаас

**Эмэгтэй.** Та тугалын мах идэх үү, котлет идэх үү?

**Эрэгтэй.** Аль алиг нь. Ингэхэд, цирк бол театр биш шүү! Жинхэнэ урлаг байгаа юм. Театрынхан юу чаддаг юм? Тайзан дээр дэмий холхиод л, хайр сэтгэл, мөнгө, өөр юу ч билээ дэмий юм бувтнаад л. Алив та үнэнээсээ хэлээч, энэ хэнд сонирхолтой гэж? Янз янзын дүрд хувираад зовж шаналаад л уйлж дуулаад байх ч амаргүй л байх лдаа. Гэхдээ энэ жүжигчид гээд байгаа хүмүүс чинь хар хурдаараа давхиж яваа морин дээр зогсоод галаар жонглёрдож чадах уу? Циркд мориноос аюултай амьтад ч бий. Жишээлбэл арслан! Та арсланд дуртай юу?

**Эмэгтэй.** Мэдэхгүй.

**Эрэгтэй.** Тэгнээ тэр. Циркд байгаа миний хамгийн сайн найз бол Султан. Та мэдээж Султаны талаар сонссон биз дээ?

**Эмэгтэй.** Огт дуулаагүй юм байна.

**Эрэгтэй.** Үгүй байлгүй дээ. Тэр бол хамгийн ууртай, цусанд шунахай циркийн арслан байгаа юм. Тэр хэнийг ч хүлээн зөвшөөрдөггүй. Өөрийнхөө сургагчийг хүртэл шүү! Харин намайг бол хүндлэнэ ээ. Яагаад гээч? Тэр надтай эн тэнцүү гэдгээ мэддэг юм. Танд тал хундага хийчих үү?

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** Тэгвэл дөрөвний нэгээр? Хань болоод ядаж уруулаа хүргэ лдээ.

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** За яахав, би уулаа шүү (*Ууна*) Гайхалтай! Дээд зэргийн, байж боломгүй сайхан нэрмэл байна.

**Эмэгтэй.** Та загас идэх үү, Омлет идэх үү?

**Эрэгтэй.** Аль альныг нь... Тэгэхлээр циркийн жүжигчидтэй эн зэрэгцэж хэн ч чадахгүй. Хамгийн хүчтэй, авхаалжтай, зоригтнууд нь бидэн дээр ирж бусад нь хаа нэгтээ, хэнд ч анзаарагдахгүйгээр алга болцгоодог юм. Манайд бүх юм нээлттэй, бүх юм шударга, бүгд дөрвөн талаасаа ил... Сайхан загас байна. Энэ хилэм үү?

**Эмэгтэй.** Мерлуза

**Эрэгтэй.** Үнэнийг хэлэхэд надад хилэм шиг л санагдлаа. Байж боломгүй, үнэхээр амттай юм ... Бид юун тухай ярьж байлаа?

**Эмэгтэй.** Загасны тухай.

**Эрэгтэй.** Үгүй, өмнө нь?

**Эмэгтэй.** Циркийн тухай.

**Эрэгтэй.** Аан, нээрэн тийм. Гэхдээ энэ талаар ярих ч илүү хэрэг л дээ. Хүүхдүүд циркд хайртай – гэхээр л бүх зүйл ойлгомжтой. Жинхэнэ урлаг! Гэхдээ бидэнд томчууд ч бас дуртай. Та байнга цирк үздэг үү?

**Эмэгтэй.** Огт үгүй.

**Эрэгтэй.** Итгэмээргүй юм. Цирк гэдэг бол баяр баясгалан, сэтгэлийн тайвшрал. Та циркд байна гээд төсөөл дөө ... эхлээд парад-алле болно, бүрээ бишгүүр хангинаад л, том том прожекторууд тусгаад л, гайхамшигтай хувцасласан хүүхнүүд, ямар хүүхнүүд гэж бодно оо! Чөтгөр аваг! ... Дараа нь акробатын гайхалтай үзүүлбэрүүд гээд л. Гэхдээ энэ бол зүгээр л эхлэл төдий. Хамгийн гол зүйл хараахан эхлээгүй байна. Тэрнийг бүгд тэсч ядан хүлээнэ дээ. Мэдээж та хөтөлбөрийн хамгийн гол зүйл хэн бэ гэдгийг таасан байх.

**Эмэгтэй.** Султан арслан уу?

**Эрэгтэй.** (*Гомдож*) Энд чинь Султан арслан ямар хамаа байна аа? (*Чимээгүй юмаа иднэ*)

**Эмэгтэй.** Та яагаад дуугаа хураачихав аа?

**Эрэгтэй.** (*шууд сэргэж*) Тийм ээ, миний яриа таныг эзэмдэж байгааг би мэдэж байна ... тэгэхлээр, үзэгчидийн тэвчээр нь барагдаж хязгаартаа тулна. Ингээд л удаан хүлээсэн мөч ч ирнэ дээ. Хангинасан хөгжим, нижигнэсэн алга ташилтан дор арван хоёр хүн асар том туйван дамжлаад гарч ирнэ. Бүгд чимээгүй болоход миний нэрийг зарлав уу үгүй юу бүх үзэгчид

шуугилдана. Би гарч ирээд л ... энийг үзэх хэрэгтэй шүү. Эмэгтэйчүүд бол ухаан алдаад л унана.

**Эмэгтэй.** Яагаад?

**Эрэгтэй.** Яагаад гэвэл хүмүүс хүч чадлыг биширдэг байхгүй юу. Энэ бүх профессорууд, нүдний шилтэй инженерүүд, бусад үлбэгэр сулбагарууд хэрэг дээрээ ганц л юм хүсдэг. Хүч чадлыг. Тэдний эхнэрүүд нь ч тэднээс ийм л юмыг хүсдэг ... та ч гайхамшигтай хоол хийх юм аа. Таны гоо үзэсгэлэнгийн төлөө! (*Ууна*) Тоглолтын дараа юу болдог гэж бодно оо! Гарын үсэг, цэцэг, болзооны урилга, оргилуун дарстай оройн зоог... дахиад нэрмэл байхгүй юу?

**Эмэгтэй.** Байхгүй

**Эрэгтэй.** Харамсалтай юм.

**Эмэгтэй.** Тэгээд ч та овоо халчихсан байна шүү дээ.

**Эрэгтэй.** Гэхдээ л уумаар байна.

**Эмэгтэй.** Танд цай юм уу, кофе өгч болох л юм.

**Эрэгтэй.** Аль альныг нь. Аа, үгүй ээ, зүгээр цай л ууя. Юу... нэрмэл дууссан гэсэн үү?

**Эмэгтэй.** Дууссан.

**Эрэгтэй.** За тэгвэл цай л ууя. Болдог бол бялуутай ч юм уу?

**Эмэгтэй.** Бялуу болоогүй байна аа.

**Эрэгтэй.** Харамсалтай юм. Гэхдээ зүгээр ээ. Та үнэхээр гайхамшигтай эзэгтэй юм аа. Би бараг цадчихлаа даа. Шуудхан хэлэхэд намайг цатгана гэдэг ч хэцүү шүү.

**Эмэгтэй.** Тийм байна, та миний долоо хоногийн хүнсийг идчихлээ.

**Эрэгтэй.** Та ойлгож байгаа биз дээ ... урлагийн хүн ... тэгээд хүнд жингийнх гэж байгаа.

*Эмэгтэй алх барин сандалаа хадаж янзална. Хоол, архинд уярсан Эрэгтэй цай ууна.*

Цирк бол цирк! Ингээд л гүйцээ. Бид үргэлж хөдөлгөөн дунд, үргэлж замд явж байдаг. Хуучны зохиолд гардаг шиг, морин тэргээр явж майханд хоноглож байдаг гэж та бодов оо. Үгүй шүү, нэгдүгээр зэргийн галт тэрэг, дээд зэргийн зочид буудлууд. Нэг л газарт сууршиж амьдардаг амьдралыг би тэвчихгүй. Дэндүү уйтгартай. Парис, Лондон, Токио, Моска гээд л хувь заяа биднийг маргааш хааш нь илгээж болох вэ, би бүгдийг нь амссан. Бүх л тивийн, бүх л төрлийн хүүхнүүдийг тэвэрч явлаа. Үдэш бүр дундуураа тас хөрөөдүүлж байдаг дэлхийд алдартай үзэсгэлэнт Стелла хүүхэн шөнө бүв бүтнээрээ миний орон дотор хэвтэж байдаг байлаа. “Ясгүй гайхамшиг” хочит энэтхэгийн циркийн од хүүхэн таны төсөөлж ч чадахгүй зүйлийг надад сургасан юм. Тэрэнд нээрэн яс гэж юм юу ч мэдэгддэггүй байсан ч бусад бүх юм байсан юм. Ховсдогч хүүхэн намайг мансууруулж, Могой-хүүхэн тас тэвэрч байлаа. Анхны хайрыг би трамплин дээр үзэж байлаа. Би ч ярих юмтай хүн шүү. Та надтай илүү дотно танилцахаараа...

**Эмэгтэй.** Гараа!

**Эрэгтэй.** Юун гар?

**Эмэгтэй.** Гараа ав гэж байна!

**Эрэгтэй.** Хааш нь?

**Эмэгтэй.** Хаашаа биш, хаанаас гээч!

**Эрэгтэй.** (*Эмэгтэйг суллаж*) Уучлаарай, харин нэг мэдсэн чинь...

**Эмэгтэй.** Ер нь ийм тохиолдолд би алхаа хэрэглэхдэг хүн шүү.

**Эрэгтэй.** Ойлголоо.

**Эмэгтэй.** Та хооллож дууслаа.

**Эрэгтэй.** Арай болоогүй байна.

**Эмэгтэй.** Би асуугаагүй байна. Таны оройн хоол дууслаа гэж хэлж байна.

**Эрэгтэй.** Та ч хоол сайн хийх юм аа.

**Эмэгтэй.** Та түрүүн ингэж хэлсэн, сайхан амраарай.

**Эрэгтэй.** Дахиад жаахан юм ярья л даа, ядаж тавхан хором.

**Эмэгтэй.** Мөн дөө, би танд хоол хийхийг зөвшөөрсөн болохоос чалчихыг чинь сонсох үүрэг хүлээгээгүй байх шүү. Та хоолоо чимээгүйхэн шиг идэж чадах уу?

*Р. (Урвайж)* Чадна л даа гэхдээ...

**Эмэгтэй.** Тэгэхлээр бид хоёр бүх зүйл дээр тохиролцож чадсан гэж ойлгож болох нь ээ? Баяртай.

**Эрэгтэй.** Байзаарай ... Танаас нэг юм асууя. Илүү үгэнд дурлаж байгаа юм биш шүү.

**Эмэгтэй.** (*Болгоомжилж*) Тэгээд?

**Эрэгтэй.** Түрээслэгчийн хувьд би нэг нөхцөл байдлыг мэдмээр байна ... эвгүй байдалд орохгүйн тулд ... та хариулах албагүй л дээ.

**Эмэгтэй.** Товчхон

**Эрэгтэй.** Энд эрэгтэй цамцнууд байх юм.

**Эмэгтэй.** Тэгээд юу гэж?

**Эрэгтэй.** Юу л даа, би энд гурав хонолоо, танаас өөр хэнийг ч харсангүй.

**Эмэгтэй.** Би таныг товчхон яриач гэж хүссэн байх аа?

**Эрэгтэй.** Товчхондоо та чинь нөхөртэй юм уу үгүй юу?

**Эмэгтэй.** Ойлгомжтой шүү дээ.

**Эрэгтэй.** Ойлгомжтой тийм юмуу? Ойлгомжтой үгүй юм уу?

**Эмэгтэй.** Ойлгомжтой тийм.

**Эрэгтэй.** (*Хэсэг зогсоц*) Тэгээд нөхөр чинь хаана байгаа юм?

**Эмэгтэй.** Бурхан минь, нөхөр минь хаана ч байж болно шүү дээ. Томилолтоор явсан, амралтанд явсан, ээжийндээ очихоор явсан, эмнэлэгт хэвтсэн... Эцсийн эцэст шоронд ч байж болно биз дээ. Танд ямар хамаа байна? Энд та түрээсээ төлөөд л амьдарвал барав. Бусад нь танд хамаагүй.

**Эрэгтэй.** Би ойлгохгүй юм. Яахаараа нөхөрсөг яриа ингэж...

**Эмэгтэй.** Сонс, та миний амьдралд, би таны амьдралд оролцохгүй гэж танд өрөө түрээслүүлэх үед л бид тодорхой тохиролцсон санагдах юм. Та өрөөний түлхүүр авсан, тэндээ юу дуртайгаа хийж болно. Дуулж, бүжиглэж, бүрээ үлээж, туухайнуудаа өргөж,

хүсвэл хүүхнүүдтэйгээ ч ирж болно. Яахав Лондон, Парис биш ч гэсэн энд зугаацчихмаар юм олдох л байх. Харин битгий надаас янз бүрийн юм асуугаад бай! *(Огцом эргэж холдоно)*

**Эрэгтэй.** *(Гайхаж)* Бурханыг бодож уучлаач ... би уг нь таныг...*(Эмэгтэйд дөхөж, гараа мөрөн дээр нь тавиад)* тайвшир л даа.

**Эмэгтэй.** Алх аваад өг.

**Эрэгтэй.** Үгүй ээ, гэхдээ би танд тийм утгаар хүрээгүй шүү... танд би үнэхээр тийм тааламжгүй санагдаж байна гэж үү?

**Эмэгтэй.** Миний хувьд та огт байхгүй, ойлгов уу?

**Эрэгтэй.** Ойлгосонгүй?

**Эмэгтэй.** *(Ядрангуй)* Явж унт!

**Эрэгтэй.** Та яах юм?

**Эмэгтэй.** Аяга таваг угаах хэрэгтэй байна.

**Эрэгтэй.** Алив би танд туслая.

**Эмэгтэй.** *(Арай дулаан өнгөөр)* Баярлалаа, гэхдээ та төлж байгаа болохоор би танд үйлчлэх ёстой.

*Эрэгтэй дуугүй явна. Эмэгтэй сав суулгаа цуглуулна.*

*Эрэгтэй буцаж ирнэ.*

**Эрэгтэй.** Өрөө огт дулаацаагүй байна. Ор гэж цасан хунгар. Ойртохын ч арга алга.

**Эмэгтэй.** Халаагуур чинь яасан юм?

**Эрэгтэй.** Мөсөн хүйтэн байна. Эвдэрхий юм байлгүй.

*Эмэгтэй Эрэгтэйн өрөөнд очоод эргэж ирнэ.*

**Эмэгтэй.** Та залгахаа л мартчихсан байна шүү дээ.

**Эрэгтэй.** Таныг сав суулгаа угааж байх хооронд би энд сууж болох уу?

**Эмэгтэй.** *(Зогсоц)* Суу суу, харин томоотой л байж үзээрэй.

*Эрэгтэй урт сандал дээр суумагцаа нурж унана.*

**Эмэгтэй.** Сандал эвдэрхий гэж танд хэлээ биз дээ.

**Эрэгтэй.** Би мартчихаж.

*Эрэгтэй түшлэгтэй сандал авч сууна. Эмэгтэй сав суулгаа угаана.*

Би бодоод байна л даа.

**Эмэгтэй.** Юун тухай?

**Эрэгтэй.** Хэний тухай гээч. Таны тухай.

**Эмэгтэй.** Үзэсгэлэнт Стеллагаа бодсон чинь дээр байлгүй дээ.

**Эрэгтэй.** Яахаараа би бусад хүмүүсийн хувьд байдаг, таны хувьд байдаггүй байна аа? Намайг хэн ч биш гэж боддог эмэгтэйтэй би нэг ч таарч байсангүй. Яахав би тийм ч залуу биш, миний нас штанганд ахадхаар болж байгаа ч эмэгтэйчүүдийн хувьд бол яг л ид насан дээрээ байгаа хүн шүү. Танд тангаргалъя.

**Эмэгтэй.** Өөрийгөө битгий зүрх булаагч болгоод бай!

**Эрэгтэй.** Та харин өөрийгөө битгий огтхон ч гар хүрээгүй, ариухан амьтан болгоод бай! Эрэгтэйчүүдтэй уулзаж байгаагүй гэх гээ юу?

**Эмэгтэй.** Ямар ч байсан байр түрээслэгчидтэйгээ л биш.

**Эрэгтэй.** Яагаад гэдэг чинь л их сонирхолтой байна.

**Эмэгтэй.** Яагаад гэвэл энэ бүхэн юугаар дуусдагийг би мэддэг юм.

**Эрэгтэй.** Юугаар гэж?

**Эмэгтэй.** Нэгдүгээрт тэд мөнгөө төлөхөө байчихдаг юм.

**Эрэгтэй.** *(Сандарч)* Цалин маань нөгөөдөр бууна. Таныг хүсвэл би...

**Эмэгтэй.** *(Үл сонсон)* Хоёрдугаарт тэд дандаа л яваад өгдөг.

*Зогсоц.*

**Эрэгтэй.** Гэхдээ зарим түрээслэгчид таны сэтгэлийг татдаггүй гэж үү?

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** Яагаад?

**Эмэгтэй.** Яагаад гэвэл би тэдний тухай бүгдийг мэддэг. Тэд хурхирна, хяхтнана, элэг бөөр гэж гомдоллоно, залхуурна, худлаа ярина, хараал хэлнэ. Бүгд идэж уунгуутаа л хүн эргүүлэх гэж оролдоно. Бүгд, бүр хамгийн аймхай нь хүртэл шүү. Жишээлбэл та эхнэргүй гэдэг чинь шууд л харагдаж байна.

**Эрэгтэй.** *(Гайхаж)* Яаж?

**Эмэгтэй.** Та зөвхөн дөрөвдөхь өдөртөө л хүн өдөж эхэлж байна. Харин эхнэртэй хүмүүс анхны өдрөөсөө л тэврэх гээд байдаг юм. Ганц бие нөхдүүд арай гайгүй байдаг бол гэр бүлтэйнүүд нь уяанаас тавигдсан юм шиг л аашилдаг юм. Гэхдээ тэр нь дөнгөж хорин дөрвөн цаг л үргэлжилнэ. Үнэнийг хэлэхэд эхнэрүүд нь тэднийг лацдачихсан байдаг юм шиг байгаа юм.

**Эрэгтэй.** Та ч эрчүүдүүдийг үнэхээр өрөвддөггүй хүн юмаа.

**Эмэгтэй.** Тэднийг юунд нь хүндлэнэ гэж? Хүн эргүүлж байгаагийг нь хардаг ч болоосой. Нэг муу цонхигор сэхээтэн хүртэл цүнхнээсээ шил юм гаргаж ирээд хань болооч гэхийг нь яана. Ойлгож байна уу? Түүнд их уйтгартай л байх шиг байгаа юм. Гэтэл тэрнээс нь болж би хугас шил юмных нь төлөө хөнжил дотроо оруулах юм байна л даа. Эрчүүдийн логик энэ үү, Аан?

**Эрэгтэй.** Гэхдээ болгооно уу?

**Эмэгтэй.** Үгүй шүү, гүйцэд сонс. Та надаас яагаад суугчидтайгаа харьцаа үүсгэдэггүй юм бэ гэж асуусан, би хариулья л даа. Эрчүүд яаж эргүүлдэг гээч? Эхлээд л намайг бишрүүлэх гэж өөрсдийгөө магтаж онгирч гарна. Дараа нь тэгээд тэднийг хэн ч ойлгодоггүй, бүр эхнэр нь ч ойлгодоггүй болохоор учиргүй ганцаардаж явдгаа ойлгуулахыг хичээнэ. Энэ чалчаа ярианыхаа завсраар намайг бас ичгүүргүйгээр магтаж гарахыг нь яана. Ингээд бэлтгэл ажил дуусч, дайралт эхлэнэ дээ. Тэгээд дайралт нь бүтэлгүйтвэл хүн хамаг цаг, архиа барчихаад байхад тэврүүлсэнгүй гээд учиргүй уурлаж гарна. Тэдний хөзөр бүгд тодорхой, тоглоом яаж өрнөх нь зуун нүүдлийн өмнөөс тодорхой байдгийг тэд ойлгохгүй л дээ...

**Эрэгтэй.** *(Тасалж)* байзаач

*Чимээгүй болно*

Таны сэтгэл их хөдөлж байх шиг байна, сэдвээ өөрчилвөл ямар вэ?

**Эмэгтэй.** *(Биеэ эзэмдэж)* Яалаа гэж, би тайван л байна шүү дээ.

**Эрэгтэй.** Тэд таныг ингэж залхааж байдаг юм бол юунд нь байлгаад байдгийг чинь ойлгохгүй юм.

**Эмэгтэй.** Яахав, амин зуулгаа олох хэрэгтэй биз дээ. Тэд намайг залхаадаг гэж та яагаад бодов?

**Эрэгтэй.** Та чинь дөнгөж сая...

**Эмэгтэй.** *(Тасалж)* Зөв өө, гэхдээ би аль хэдийнэ тэд тэндээ, би эндээ гэдэг систем боловсруулсан юм. Тэд бол миний хувьд торны цаана байгаа амьтны хүрээлэнгийн араатнууд л гэсэн үг.

**Эрэгтэй.** Тэгээд тус болж байх юм уу?

**Эмэгтэй.** Тэгэлгүй яахав. Хэн нэгэн заваан новшийг харах нэг хэрэг, харин тэрэнтэй амьдарч, нэг оронд цуг хэвтэнэ гэдэг өөр хэрэг. Таныхаар бол ямар байх вэ? ялгаа байна уу?

**Эрэгтэй.** Тэхдээ л би таны оронд байсан бол эмэгтэйчүүдэд л өрөө түрээслүүлэх байсан.

**Эмэгтэй.** Эмэгтэйчүүд томилолтоор явах нь цөөн, тэгээд ч бага төлдөг юм. Тэрнээс гадна илүү үгэнд дуртай. Миний хэрэгт хүн оролцохыг би тэвчдэггүй юм.

**Эрэгтэй.** Бурханы авралаар эрчүүдэд нэг сайн шинж олдож дээ.

**Эмэгтэй.** Гэхдээ тэд нэг л юмыг, намайг нөхөртэй эсэхийг л сонирхдогийг хэлэх хэрэгтэй.

**Эрэгтэй.** Үгүй ингэхэд та чинь тэгээд нөхөртэй хүн үү?

**Эмэгтэй.** Ядаж та ийм тэнэг асуултаар намайг битгий оролдоод байгаач. Би нөхөртэй гэж хэлээ биз дээ.

**Эрэгтэй.** Хэр удаж байгаа юм.

**Эмэгтэй.** Арван хоёр жил

**Эрэгтэй.** Нөхөр чинь тэгээд томилолтоор явчихсан байгаа юмуу?

**Эмэгтэй.** Тэр намайг хаяад явсан.

**Эрэгтэй.** Та хоёр удаан амьдарсан уу?

**Эмэгтэй.** Арван нэгэн сар.

**Эрэгтэй.** Тэр одоо хаана байгаа юм бэ?

**Эмэгтэй.** Ёстой бүү мэд

**Эрэгтэй.** Та тэрэндээ хайртай хэвээр үү?

**Эмэгтэй.** Тэнэг юм битгий яриад бай, би ямар царайтайг нь ч мартчихаж.

**Эрэгтэй.** Тэр цагаас хойш та тэгээд ганцаараа амьдарч байгаа юм уу?

**Эмэгтэй.** Ер нь бол, тиймээ.

**Эрэгтэй.** *(Цамцнуудруу хялам хийж)* Та одоо ч гэсэн ганцаараа юу?

**Эмэгтэй.** Бурханыг бодож наад байцаалтаа зогсоогооч, энэ чинь ямарч утга алга.

*Зогсоц. Эрэгтэй цонхон дээр очно.*

**Эрэгтэй.** Бороо орсоор л байна.

**Эмэгтэй.** Тийм байна.

**Эрэгтэй.** Зун ид дундаа орж байдаг, ийм цаг агаар ч байх гэж.

**Эмэгтэй.** *(Салхи шуугих, бороо шаагихыг сонсон)* Арван нэгдүгээр сараас ч дор байх шив дээ.

**Эрэгтэй.** Ямар харанхуй байна аа, танай цонхны цаана юу байгаа юм бэ?

**Эмэгтэй.** Цэцэрлэг.

**Эрэгтэй.** Ийм том хотод бас өөрийн цэцэрлэгтэй?

**Эмэгтэй.** Хотын захад байгаа шүү дээ.

**Эрэгтэй.** Тэгэхлээр та чинь бараг гэрээсээ гардаггүй байх нь ээ?

**Эмэгтэй.** Тэгээд юу гэж?

**Эрэгтэй.** Та чинь ажил хийдэггүй хүн үү?

**Эмэгтэй.** Хийдэг.

**Эрэгтэй.** Ямар мэргэжилтэй юм?

**Эмэгтэй.** *(Мөрөө хавчин)* Эмэгтэй хүн.

**Эрэгтэй.** Энэ чинь мэргэжил биш шүү дээ.

**Эмэгтэй.** Яагаад?

**Эрэгтэй.** Яагаад гэвэл...яагаад гэвэл энэний төлөө цалин өгдөггүй шүү дээ.

**Эмэгтэй.** Дэмий л хэрэг дээ, шударга биш байна, эмэгтэй хүн байна гэдэг чинь хамгийн хэцүү мэргэжил.

**Эрэгтэй.** Жишээлбэл надад, эрэгтэй хүн байсны минь төлөө надад хэн ч мөнгө төлдөггүй шүү дээ.

**Эмэгтэй.** Мэргэжлээрээ та чинь эрэгтэй хүн биш циркийн жүжигчин шүү дээ. Харин би бол онгоцны үйлчлэгч, нягтлан бодогч, холбоочны алин нь ч биш. Зүгээр л эмэгтэй хүн. Би юм оёж, хоол хийж, угааж, юм нэхэж, гитар тоглож, дуулж, өвчтөнг асарч, гэр болон цэцэрлэгээ арчилж чаддаг ...

**Эрэгтэй.** Энэ ч сайн хэрэг шүү.

**Эмэгтэй.** Би ер нь эмэгтэй хүний хийх ёстой бүх зүйлийг маш сайн хийж чадна. Харин өөр юу ч чадахгүй.

**Эрэгтэй.** Хэрэггүй хэрэггүй, тэгээд ч хангалттай их байна. Таны жигнэсэн ганцхан тугалын махны төлөө би сэтгэлээ өгөхөд ч бэлэн байна. Тэр таныг орхиод явсан гэдэгт үнэндээ итгэмээргүй юм. юу болсон юм?

**Эмэгтэй.** Санахгүй байна, аль эртний явдал шүү дээ.

**Эрэгтэй.** *(Мөрөөр нь болгоомжтой тэвэрч)* Аль хэдийнэ салсан байж, та яагаад нөхөртэй гээд байсан юм?

**Эмэгтэй.** Яагаад ий? *(Хэсэг дуугүй байснаа, чангаар хөхөрнө)*

**Эрэгтэй.** Та чинь яагаад инээгээд байна аа?

**Эмэгтэй.** Яагаад гэвэл бид ердөө ч салаагүй, би танаар тоглосон юм.

**Эрэгтэй.** *(Үл ойлгон)* Тоглосон гэдэг чинь юу гэсэн үг вэ?

**Эмэгтэй.** Маш энгийн. Таныхаар бол энэ цамцнууд хэнийх болж таарч байна? Минийх үү? Би хэнд бялуу жигнэсэн хэрэг вэ? Төсөөлж байна уу, танд гэж үү? Хэрэв ээ мэдэхийг хүсч байвал миний нөхөр гайхамшигтай хүн байдаг юм шүү.

**Эрэгтэй.** Тэгээд тэр чинь хаана байгаа юм.

**Эмэгтэй.** Ажлаар явсан, гэхдээ одоо хэзээ мөдгүй орж ирэх ёстой.

**Эрэгтэй.** (*Эмэгтэйн мөрөн дээрээс нь гараа авч*) Тун ч санамсаргүй юм боллоо. Би ч явъя даа.

**Эмэгтэй.** Та хайчих нь вэ? Байж бай л даа, би та хоёрыг танилцуулья.

**Эрэгтэй.** (*Царайгаа барайлган*) Баярлалаа, дараа больё, одоо их орой болсон байна.

*Туухайнуудаа авч үүд рүү зүглэнэ.*

Сайхан амраарай.

*Эмэгтэй солирсон хүн шиг инээнэ. Эрэгтэй зог тусна.*

**Эрэгтэй.** Та чинь юундаа инээгээд байна аа?

**Эмэгтэй.** Та одоо ойлгов уу? (*Инээдэндээ хахаж цацна*)

**Эрэгтэй.** Юуг?

**Эмэгтэй.** Намайг яагаад нөхөртэй гэж хэлсэн гээч...

(*Үргэлжлүүлэн инээнэ*) Та нар байр түрээслэгчид ... ха ха...ха... хамгийн өөдгүйгээсээ авахуулаад хамгийн хүчтэн нь хүртэл нөхөр одоо ирнэ гэж хэлэв үү үгүй юу савараа татаж аваад л оромж руугаа зугтах юм.

**Эрэгтэй.** (*Учираа олохоо байж*) Тэгэхлээр та...

**Эмэгтэй.** (*Сонсолгүй*) Яагаад гээч? Мэдэж байна уу? яагаад гэвэл та нар бүгд, штангийн аварга нь хүртэл хүний ор луу сэмхэн мөлхөхийг л чадахаас жинхэнэ хайр сэтгэл гэж юу байдгийг мэдэхгүй!

*Эмэгтэй үргэлжлүүлэн инээсээр байна. гэхдээ инээд нь аяндаа уйлахаар солигдно. Эрэгтэй хажууд нь хөшиж туухайгаа барьсан хэвээр зогсоно.*

**Эрэгтэй.** За ...болилдоо (*Түүнрүү дөхөж очоод*) та чинь уйлаад байгаа юмуу даа, тайвшир. (*Сая л нэг юм туухайгаа хаяж, шилэн аяганд ус хийж эмэгтэйд барина*) Май энийг уучих.

**Эмэгтэй.** (*Аягатайг түлхэж*) Хэрэггүй ээ.

**Эрэгтэй.** Та чинь яаваа?

**Эмэгтэй.** (*Нулимсаа арчин*) Зүгээрээ, (*Ууртайгаар*) над руу битгий хараад бай. (*Пудрээ гаргаж ирэн буруу харж нүүрээ янзлана. Тэгээд шилэн аяга авч доторх усыг нь асган шүүгээн дотроос шил архи гарган задалж шилэн аяганд хийж ууна*)

**Эрэгтэй.** Танд одоо дээр болж байна уу?

**Эмэгтэй.** (*Хайхрамжгүй дуугаар*) Тиймээ одоо зүгээр болчихлоо, та битгий ай, дахин ийм юм болохгүй.

**Эрэгтэй.** За энэ тухай мартья.

*Зогсоц*

Гэрлэлт ч танд үнэхээр гай болж дээ.

**Эмэгтэй.** Бусдынхтай л адил.

**Эрэгтэй.** Нөхөр чинь танд яаж ханддаг байсан юм?

**Эмэгтэй.** (*Мөрөө хавчин*) Тэр чинь эрэгтэй хүн байсан юм.

**Эрэгтэй.** Энэ чинь хариулт бишээ, тэр танд хайртай байсан уу?

**Эмэгтэй.** Тэр хажуудаа уураа гаргаж, дарлаж, шим шүүсийг нь сорж байх хэн нэгэн өөрөөс нь сул дорой хүнийг байлгаж байх дуртай байсан юм. Эрчүүд чинь өөрийг нь арчилж, тэжээж, угааж, оронд нь хэвтүүлж

өгч байдаг хүнд л дуртай байдаг юм. Тэгэхлээр хайртай байсан гэж тооцож болох байлгүй.

**Эрэгтэй.** Аан гээч, хэрэв иймдээ тулж байгаа бол эмэгтэйчүүд ч гэсэн бурам биш шүү.

**Эмэгтэй.** Өө тийм үү?

**Эрэгтэй.** Тэд нар байнга л шалгааж, үглэж, яншиж байдаг. Та тэдний гол араншинг мэдэх үү?

**Эмэгтэй.** (*Тавласан маягтай*) Хуваалцаач.

**Эрэгтэй.** Нөхрөө үзэн ядна, хөршүүддээ атаархана, дэмий юманд л дурлана. (*Чин үнэнээсээ*) Тэд амьдралыг яаж хүндрүүлдэг гэж бодноо!

**Эмэгтэй.** Таныхыг бас хүндрүүлчихсэн үү?

**Эрэгтэй.** Тэгэлгүй яахав, урьд нь тэгж байсан. Одоо би тэднээс аль болох хол байхыг хичээдэг юм.

**Эмэгтэй.** (*Егөөдөж*) Өө, за үнэхээр тийм үү?

**Эрэгтэй.** Та намайг гаднаас нь хараад ичгүүр сонжуургүй амьтан гэж битгий бодоорой, хэрэг дээрээ би их ичимхий хүн шүү. Заримдаа бүр ичсэнээсээ болоод хаашаа орохоо ч мэдэхээ больчихдог.

**Эмэгтэй.** (*Хорон*) Энийг ч би аль түрүүн ажигласан.

**Эрэгтэй.** Та дэмий л тэгж бодож байна. Яахав, би хүүхнүүдтэй жаахан хөнгөмсөг байсан байж магадгүй...

**Эмэгтэй.** Тэднийг таньдаггүй.

**Эрэгтэй.** Гэхдээ л би тэдэнд сэтгэл хөрчихөөд байгаа юм.

**Эмэгтэй.** Шал балай юм. Таны нас уу? Муу хоол унднаас болоо юу?

**Эрэгтэй.** (*Илт гомдож*) Байзаач, та чинь яагаад ингэж байнга намайг доромжлоно вэ?

**Эмэгтэй.** Энийг харин би танаасуумаар байна. Та яагаад намайг манай гэрт доромжлоод байгаа юм бэ?

**Эрэгтэй.** Доромжлох оо? Таныг уу?

**Эмэгтэй.** Таны юу гэх гээд байгааг ойлгоогүй гэх нь үү?

**Эрэгтэй.** Юу гэж? Би ер нь эмэгтэйчүүдийн тухай л ярьсан болохоос.

**Эмэгтэй.** Намайг л оньлоод байсан биз дээ. тэгэхлээр сонсож бай (*Улам уурлаж*) таныхаар би үглэж яншдаг, шалтгаангүйгээр эрчүүдийг муулдаг, нөхрийгөө ойлгож тогтоож чадаагүй юм байна, харин та эндээс хөөгдөтлөө чимээгүй байх ёстой биш үү?

**Эрэгтэй.** За яахав, та энийг өөр дээрээ тусгаж байгаа бол тийм л болог. Та мэдэж байгаа биз, би маргахгүй ээ.

**Эмэгтэй.** Би ч гэсэн, нэг муу азгүй, хүүхэмсэг, дээр нь онгиороо чалчаа амьтантай маргалдаж баймааргүй байна.

**Эрэгтэй.** (*Дүүрэн амьсгал авч*) Харин та ... ганцаардмал могой. Та яагаад эрчүүдэд уурлаад байгаагаа мэдэж байна уу? Яагаад гэвэл тэд таныг аль хэдийнэ хаяад явчихсан. Тэгээд ч тэд эргэж ирэх ч үгүй. Галзуурсан морь шиг л хүн бүхэн рүү өшигчөөд байх юм.

**Эмэгтэй.** (*Уурандаа багтарч*) Заримдаа муусайн азаргануудыг өшигчиж байх хэрэгтэй.

**Эрэгтэй.** Азарганы тухай мөрөөдөөд ч хэрэггүй. Хэнд ийм хатсан өргөс юм хэрэгтэй юм.

**Эмэгтэй.** *(Галзуурч)* Та адгийн шаар. Маргааш гэхэд зайлаарай.

**Эрэгтэй.** Яагаад маргааш гэж, одоохон яваад өгье. Шөнө та намайг багалзуурдчих ч юм бил үү.

**Эмэгтэй.** Одоо явах гэж байгаа бол бүр л сайн байна. Мөнгөө төлөөд зайлж үз.

**Эрэгтэй.** Болж байна. Гэхдээ цалин нөгөөдөр буух ч танаас зайлахын тулд байгаа бүхнээ өгөөд явахад бэлэн байна. *(Гараа савлан ширээн дээр түрийвчээ шиднэ)* Бүгдийг нь ав!

**Эмэгтэй.** Илүү мөнгө надад хэрэггүй ээ, авах ёстойгоо л аваад болно.

*Эмэгтэй ширээнд дөхөж түрүүвчийг нээнэ. Эрэгтэй хурдан хөдөлж эмэгтэйг тэвэрч аван биедээ шахна.*

**Эрэгтэй.** Гүйцээ та одоо хөдөлж чадахгүй.

**Эмэгтэй.** *(Цочирдож, мултрах гэж зүтгэнэ)* Та чинь бүр галзуурав уу? Тавиач!

**Эрэгтэй.** Битгий зүтгээд бай, энэ ямар ч ашиггүй гэдгийг та мэдэж байгаа шүүдээ. Би тан шиг таван ч хүнийг хөдөлгөхгүй бариад байж чадна.

**Эмэгтэй.** *(Мултрахыг оролдож)* Муухай савраа аваач!

**Эрэгтэй.** Тэгж ч ярихгүй шүү, та надад ухаангүй таалагдаж байна.

**Эмэгтэй.** Та чинь бас яачихав аа?

**Эрэгтэй.** Таны дургүй зочдын хийдгийг хийж байгаагаа ойлгож байна аа. Бас би бүдүүлэг, дээр нь та намайг үзэн ядаж байгааг мэдэж байгаа боловч би өөрийгөө яаж ч чадахгүй байна.

**Эмэгтэй.** Та намайг туухайгаа барьж байгаа юм шиг бариад байна. Өвдөж байна шүү дээ.

**Эрэгтэй.** Мултрахыг оролдохгүй бол зөөллөж болно оо.

**Эмэгтэй.** Анхаарал тавьсанд баярлалаа.

**Эрэгтэй.** Эрчүүд бүгд таныг оролддог гэж та хэллээ, энүүнд харин та л өөрөө буруутай. Танд хүн татах ямар нэг соронзон, эсвэл амтат бал, үзэм ч юмуу нэг юм шингэчихсэн юм байна ... Чөтгөр гэж, та ч үнэхээр сэтгэл татам бүсгүй юмаа.

**Эмэгтэй.** Тиймээ, миний буруу, ингэж амархан согтохыг чинь мэдсэн бол архи өгдөггүй л байж.

**Эрэгтэй.** Таны араншин ч гэж жинхэнэ эмгэн шулам юмдаа. Гэхдээ энэ хамаагүй ээ. Таны үс үнэхээр сайхан ... үзэсгэлэнтэй амьд нүд ... би бусад юмны тухай яриагүй байна шүү.

**Эмэгтэй.** *(Ядарч)* бурхан минь энэ бүхэн ямар тэнэг юм бэ!

**Эрэгтэй.** Үнэнээ хэлье, би тэр хүйтэн ор, хоосон өрөө рүү үхсэн ч очихыг хүсэхгүй байна. ... Би ганцаардлыг тэвчдэггүй. *(Зогсоц)* За одоо би бүхнээ хэллээ, одоо намайг яасан ч болно.

*Эмэгтэйг тавьж хажуу тийш болно.*

**Эмэгтэй.** *(Хувцас, үсээ янзлан)* Би юуг ч тэвчиж байсан. Гэхдээ энэ бүгд арай хэтэрч байна.

**Эрэгтэй.** Таныг тавьсандаа харамсчихлаа, та ямар зөөлөн, дулаахан юм бэ.

**Эмэгтэй.** Тантай нэг гэрт нэг минут ч цуг баймааргүй байна. яв!

**Эрэгтэй.** *(Унжардуухан, буланд сууж)* Та надаас айх хэрэггүй.

**Эмэгтэй.** Та яв.

*Эрэгтэй өрөөрүүгээ удаанаар явж хэсэг хугацааны дараа гарч ирээд цуваа өмсөнө. Явдлаа удаашируулж, чемодан, туухайнуудаа барьж зогсоно.*

**Эрэгтэй.** Би явлаа шүү.

**Эмэгтэй.** Новшнуудаа аваарай.

**Эрэгтэй.** *(Гартаа туухайнуудаа барин)* Би авсаан.

**Эмэгтэй.** Танд өөр юм байдаггүй юмуу?

*Эрэгтэй толгой сэгсэрнэ*

Тэгээд хаана байгаа гэж, циркэд үү?

**Эрэгтэй.** Надад ерөөсөө өөр юм юу ч байхгүй. *(Удааширч)* Баяртай, уучлаарай. *(Хаалга руу явна)*

**Эмэгтэй.** Байзаарай ... түрийвчээ аваач.

*Эрэгтэй юу ч хариулалгүй гарч явна. Ганцаараа үлдсэн эмэгтэй шийдэмгий бус зогсож байснаа, цонхруу түргэн очиж онгойлгоно. Гал тогоонд салхи, борооны чимээ орж ирнэ. Эмэгтэй хаширч*

Хөөе, битгий яваач! Сонсч байна уу? Буцаад ир!

*Эмэгтэй цонхыг хаана. Хэсэг хугацааны дараа эрэгтэй орж ирнэ. Цувнаас нь ус дусана.*

Наад тэнэг туухайнуудаа тавиад цуваа тайл

**Эрэгтэй.** Тэгэхлээр та чинь намайг хөөхөө больж байгаа юмуу?

**Эмэгтэй.** Гадаа ийм байхад та хаашаа явах вэ дээ.

**Эрэгтэй.** *(Цуваа тайлан)* хэргийн учир ч цаг агаарт байгаа юм биш л дээ...

**Эмэгтэй.** Харин маяглахгүй шүү.

**Эрэгтэй.** За.

**Эмэгтэй.** Явж унт.

*Эрэгтэй өрөөрүүгээ орно. Эмэгтэй гал тогоог цэвэрлэж гэрэл унтраагаад өрөөрүүгээ орно. Нам гүм байдал. Эрэгтэй дахин гарч ирж сулханаар эмэгтэйн хаалгыг тогшино. Эмэгтэй хаалганы цаана халаттай зогсоно.*

**Эрэгтэй.** Уучлаарай ... надад дахиад нэг хөнжил өгөхгүй юу?

**Эмэгтэй.** Халаагуур чинь ажиллаагүй байна уу?

**Эрэгтэй.** Мэдэхгүй ... би бүүр даараад л байна.

**Эмэгтэй.** *(Эрэгтэйд хөнжил авчирч өгнө)* Байзаач, та бүр чичирчихсэн байна.

**Эрэгтэй.** Тиймээ, нэг л тохигүй байна. Уучлаарай, сайхан амраарай ...

**Эмэгтэй.** *(Эрэгтэйг барьж)* Хүлээгээч ... таныг даараасай гэж би хүсэхгүй байна. ...

*Эрэгтэйг тэвэрч авна. Эрэгтэй хөнжлөө алдаад эхэндээ зориг муутайгаар, дараа нь халуунаар эмэгтэйг тэврэн авна*

Нэг дүгээр үзэгдэл төгсөв.

## Хоёрдугаар үзэгдэл

*Маргааш өглөө нь. Өрөөнөөс Эмэгтэй гарч ирээд, хөшигөө ярж, толины өмнө үсээ самнана. Цахилгаан тулган дээр данх, тогоо тавьж, цэцэг услаад угаасан хувцасаа мушгиж өлгөх зэрэг ажил хийнэ. Энэ хоорондоо туухайнуудад нэг хоёр удаа бүдэрч, тэдгээрийг холдуулах гэсэн боловч өргөж дийлэхгүй учраас болино.*

*Энэ мэт зүйлсийг хийж нилээн удсаны дараагаар Эмэгтэйн гарч ирсэн өрөөнөөс Эрэгтэй гарч ирнэ. Хөлдөө шаахайтай, цамцгүй, харахад нойр дутуу, үсээ самнаагүй ч ихэд сэтгэл хангалуун байна. Эмэгтэйг үнсэхээр инээмсэглэн дөхөж очно.*

**Эрэгтэй.** Сайн байна уу? Баяр баясгалан минь?

**Эмэгтэй.** (Эрэгтэйгээс мултарч) Өглөөний мэнд!

**Эрэгтэй.** Сэтгэл санаа хэр байна?

*Эмэгтэй үл хариулах агаад Эрэгтэй сэтгэл хангалуунаар сунуана.*

**Эмэгтэй.** Өглөөжин л хөлд тээглээд байх юм, наад туухайнуудаа холдуулаач.

**Эрэгтэй.** (Эмэгтэйг тэврэхийг завдан) Юу болов оо? Чи чинь яачихав аа?

**Эмэгтэй.** (Тэврэлтээс мултарч) Намайг биш ээ туухайнуудаа зайлуул гэж байна.

**Эрэгтэй.** Юу болоов?

**Эмэгтэй.** Юу ч болоогүй.

**Эрэгтэй.** Гэхдээ чи нэг л хөндий байна даа.

**Эмэгтэй.** Би зочиддоо дандаа л ингэж ханддаг юм.

**Эрэгтэй.** Тиймээ, гэхдээ зочиддоо... харин бид одоо хамаагүй хүмүүс биш биздээ?

**Эмэгтэй.** Өө, хэзээ бид чинь хамаатай болчихов оо?

**Эрэгтэй.** Үгүй яахав ... болоод өнгөрсөн явдлын дараа.

**Эмэгтэй.** Энэ тохиолдолд танд хэдэн хамаатан байгааг би төсөөлж байна аа.

**Эрэгтэй.** Би ... уг нь ...

**Эмэгтэй.** Дэмий биз дээ.

**Эрэгтэй.** Би бодохдоо ...

**Эмэгтэй.** Бодох хэрэггүй ээ.

**Эрэгтэй.** Тэгэхлээр чи ...

**Эмэгтэй.** Та гээч.

**Эрэгтэй.** Тэгэхлээр чамд...

**Эмэгтэй.** Танд гээч.

**Эрэгтэй.** За яахав, тэгэхлээр... танд энэ шөнө юуг ч өөрчлөөгүй байх нь ээ?

**Эмэгтэй.** Амьдралын аахар шаахар юманд би нэг их ач холбогдол өгөөд байдаггүй л дээ.

**Эрэгтэй.** Энэ тэгээд аахар шаахархан л юм гэж үү?

**Эмэгтэй.** Миний хувьд иймэрхүү үйл явдлууд надад ямар ч үүрэг хүлээлгэдэггүй.

**Эрэгтэй.** Тэгэхээр бид хоёрын хооронд болсон ...

**Эмэгтэй.** (Тасалж) Юу? Яг юу болсон гэж? Халаагуур ажиллаагүйгээс солих хэрэг гарсан. Эзэгтэйн үүргээс нэг их хэтрээгүй л байх.

**Эрэгтэй.** Та энэ талаар харамсаж байгаа юм шиг л байх чинь.

**Эмэгтэй.** Бид хоёр сайхан л унтлаа, юунд харамсах гэж?

**Эрэгтэй.** Энэ талаар ийм тайван ярьж байгаад чинь гайхаж байна.

**Эмэгтэй.** Таны амьдралд эргэлт гарсан юм шиг битгий царайл. Таны хувьд би үзэсгэлэнт Стэлла, Могой-хүүхэн хоёрын чинь хоорондох л нэг үзэгдэл. Та хөтөлбөртөө орсон энэ нэмэлт номерт сэтгэл дундуур байгааг чинь мэдэж байна аа.

**Эрэгтэй.** Та юу хэлнэ вэ, яалаа гэж сэтгэл дундуур байх билээ. Харин ч эсэргээрээ.

**Эмэгтэй.** Тийм бол таны өмнөөс би баяртай л байна.

**Эрэгтэй.** Танд надтай байх сайхан байгаагүй гэж үү?

**Эмэгтэй.** Явж гар нүүрээ угааж, өөрийгөө янзал.

*Эрэгтэй мөрөө унжуулан угаалгын өрөө рүү явна.*

*Эмэгтэй талх хэрчиж ширээ засна. Эрэгтэй цэмцийгээд гарч ирнэ.*

**Эрэгтэй.** Би цамцаа олохгүй байна.

**Эмэгтэй.** Би тэрнийг чинь угаачихсаан, цагийн дараа гэхэд хатчихна. Одоохондоо миний халатыг нөмөрч бай.

**Эрэгтэй.** Баярлалаа.

**Эмэгтэй.** Зүгээр дээ. Та мөнгөө төлж байгаа учраас би танд үйлчлэх ёстой.

**Эрэгтэй.** Шөнө болсон явдал бас төлбөрт үйлчилгээ байсан юмуу?

**Эмэгтэй.** (Далд гунигтай) Үгүй ээ, би өөрийнхөө таашаалыг өөрөө л хариуцна.

**Эрэгтэй.** Ухай, тэгэхлээр танд ямар ч байсан сайхан байсан байх нь ээ?

**Эмэгтэй.** Мэдээж шүү дээ. Би бусадтай л адилхан хүн.

**Эрэгтэй.** Гэхдээ та чинь эрчүүдийг үзэн яддаг биз дээ.

**Эмэгтэй.** Гэвч энэ бол тэд надад огт хэрэггүй гэсэн үг биш.

**Эрэгтэй.** (Эмэгтэй рүү дөхөж) Аан гээч, чи надаар тоглоом хийгээд байгаа юм биш биз? Шөнө чи шал өөр байсан шүү дээ.

**Эмэгтэй.** Ямар ч байсан холхон байгааг.

**Эрэгтэй.** (Эмэгтэйг тэврэхийг оролдон) Би нэг л ойлгохгүй байна, бид хоёрт хоёуланд нь сайхан байсан байтал ...

**Эмэгтэй.** (Ууртайгаар) намайг битгий оролд! Юу ч болоогүй, юу ч өөрчлөгдөөгүй гэдгийг мэдэж ав!

*Зогсоц.*

**Эрэгтэй.** Тэгэхлээр бид хоёр дахиад л харийн хүмүүс гэсэн үг үү?

**Эмэгтэй.** (Удаанаар) Бид өөрөөр байж болно гэж үү?

*Зогсоц. Цонхны шилийг борооны ус ширүүнээр балбана.*

**Эрэгтэй.** Бороо асгарсаал л байна.

**Эмэгтэй.** Өглөөний цайгаа уух уу?

**Эрэгтэй.** (Сэргэж) Дуртайяа.

**Эмэгтэй.** Тэгвэл ширээнд суу. *(Эрэгтэйрүү халат шийднэ)* Ядаж халат өмсөөч. Ингээд байж байгаа чинь эвгүй байна.

*Эрэгтэй халат өмсөн ширээний ард сууна. Эмэгтэй түүн рүү хоёр таваг барин дөхөж ирнэ.*

Хонины мах уу? Дэгдээхэй юу? За за, би мэдэж байна.

*Эрэгтэйн урд хоёуланг нь тавихад тэр дуртайя идэж гарна.*

Өнөөдөр хоёр тоглолттой юу?

**Эрэгтэй.** Үгүй ээ, орой л ганц тоглоно.

**Эмэгтэй.** Ирдгээрээ л ирэх үү?

**Эрэгтэй.** Мэдэхгүй ээ, оройтож ч магадгүй. Энэ шүтэн бишрэгч хүүхнүүдийг ... та ойлгож байгаа биз дээ. Ингэхэд над дээр ямар нэгэн эмэгтэй зочилж ирвэл та дургүйцэхгүй биз дээ.

**Эмэгтэй.** Таны хэрэг надад хамаагүй гэж түрүүн хэлсэн биз дээ.

**Эрэгтэй.** За сайн байна, тэгэхлээр би хүнтэй ирж магадгүй шүү.

**Эмэгтэй.** Хэн дуртайгаа л авчир. Харин хэзээ ирэх ээ л хэл.

**Эрэгтэй.** Танд ямар ялгаа байна аа? Миний хэрэг хамаагүй гээ биз дээ. Үүрээр ч ирэх юм билүү.

**Эмэгтэй.** Тэгэхлээр оройн хоол бэлдэх хэрэггүй гэсэн үг үү?

**Эрэгтэй.** *(Сандарч)* Үгүй үгүй яалаа гэж. Заавал бэлд.

**Эмэгтэй.** Гэхдээ би таныг өглөө болтол хүлээж чадахгүй.

**Эрэгтэй.** Хүлээх хэрэггүй ээ, би цагтаа ирэхийг хичээнэ.

**Эмэгтэй.** Таны зочдыг хооллож чадахгүй шүү.

**Эрэгтэй.** Би энийг бодсоон. *(Зажлахаа зогсож)* Байзаач яахаараа би ганцаараа Барон шиг идээд байж байдаг, та ажиллаад байж байдаг билээ.

**Эмэгтэй.** Зүгээр ээ.

**Эрэгтэй.** Тэгж таарахгүй. Өглөөний цайгаа цугтаа ууя.

**Эмэгтэй.** Үгүй ээ үгүй, би уухгүй.

**Эрэгтэй.** *(Сэрээгээ тавьж)* Тэгвэл би ч болилоо. *(Шийдэмгийгээр тавгаа түлхэнэ)*

**Эмэгтэй.** За яахав таныг тэгж хүсээд байвал...*(Өөртөө таваг тавьж ширээнд сууна. Хоёул хооллоно)*

**Эрэгтэй.** Өнөөдөр та завтай юу?

**Эмэгтэй.** Завгүй.

**Эрэгтэй.** Ажилд явна гэж үү?

**Эмэгтэй.** Тийм, бас үгүй. Би гэртээ ажилладаг, та харж байгаа биз дээ. *(Өлгөөтэй цамцнууд руу дохино)*

**Эрэгтэй.** *(Байдлыг ойлгож)* Аан тийм үү, *(Сэтгэл хангалуунаар)* тэгэхлээр та чинь оёдог байх нь ээ. *(Цамцнуудыг үзэж)* маш сайн цамцнууд байна... Захиалга уу?

**Эмэгтэй.** Үгүй ээ, үйлдвэрийн гэрээгээр.

**Эрэгтэй.** Гайгүй төлдөг биз?

**Эмэгтэй.** Төлсөн л болдог юм. Гэтэл гэрт засвар, арчилгаа гээд юу мундах билээ.

*Эмэгтэй ширээ цэвэрлэж Эрэгтэй цамцнуудыг ихэд сонирхож барьж үзнэ.*

**Эрэгтэй.** Миний цамц ч хуучирчихаад л байгаа.

**Эмэгтэй.** Гийм байна лээ.

**Эрэгтэй.** Дэлгүүрээс надад таарах юм бараг олддоггүй юм. Гэтэл та ийм сайн оёдог...

**Эмэгтэй.** Тэгээд юу гэж?

**Эрэгтэй.** *(Гуйж)* Намайг авраач, надад цамц оёод өгнө үү. Би мөнгийг нь төлнө шүү.

**Эмэгтэй.** *(Эргэлзсэн байдлаар эрэгтэйрүү харж)* Би ийм биетэй хүнд ерөөсөө оёж байгаагүй юм байна, чаддаг болов уу яадаг бол.

**Эрэгтэй.** Та чаднаа.

**Эмэгтэй.** *(Даавуу гаргаж ирж)* Энэ материал танд таалагдаж байна уу?

**Эрэгтэй.** Маш сайхан өнгөтэй юм байна.

**Эмэгтэй.** За яахав, би үзээд алдъя. Эгц зогсоорой. *(Метр барьж Эрэгтэйгээс хэмжээ авна)* Пөөх! *(Тоо бичиж тэмдэглэж авна)* Гараа өргө... битгий эргэлдээд бай ... таны энэ хэмжээ... хоёр цамцны даавуу орох нь.

**Эрэгтэй.** Би хоёр дахин төлнө өө.

**Эмэгтэй.** Үйлдвэрийн үнээр л төлнө шүү дээ. *(Оёдлын машин өргөхөөр завдахад Эрэгтэй урьтаж машиныг ширээн дээр тавьж өгнө)*

Баярлалаа.

*Эмэгтэй түргэн шалмагаар даавууг эсгэнэ. Эрэгтэй тэрний ажил руу үе үе харна.*

Та өөрийнхөө юмыг хийж болно оо.

**Эрэгтэй.** *(Унжийж)* Орой болтол надад хийх ажил байхгүй ээ. Танд туслах уу?

**Эмэгтэй.** Та надад юу хийж өгч туслах вэ дээ.

**Эрэгтэй.** Мэдэхгүй. *(Бодолхийлснээ)* Магадгүй танд хувцасны шүүгээ дээврийн хонгилд гаргах ажил байгаа ч юм билүү?

**Эмэгтэй.** *(Инээмсэглэж)* Үгүй дээ. За яахав та үнэхээр ямар нэг юм хиймээр байгаа юм бол, пийшин галлахгүй юу. Та чинь даараад байгаа биз дээ. Гал түлж чадах юм байгаа биз дээ?

**Эрэгтэй.** Энүүнд чинь чадаж ядах юу байна аа.

*Эрэгтэй яаралгүй мод хагалж зууханд гал түлнэ. Эмэгтэй эсгүүрээ дуусгаж цамцыг хурдан торгоож шийднэ.*

Та яасан хурдан оёдог юм бэ?

**Эмэгтэй.** Сурчихсан юм.

**Эрэгтэй.** Танай галын шилээвэр муруйчихаж, би тэгшилчих үү?

**Эмэгтэй.** *(Гайхан харж)* Тэгшил л дээ.

*Эрэгтэй нарийхан утас барьсан юм шиг л хялбархан тэгшилж, зуухан доторх гал хутгана.*

**Эрэгтэй.** Гал түлэнгүүт их тухтай болж байна шүү тиймээ? Танай байшин ч их сайхан юмаа, та энд удаан амьдарч байна уу?

**Эмэгтэй.** Төрсөн цагаасаа л.

**Эрэгтэй.** Таны эцэг эх чинь амьд уу?

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** Ах, эгч бий юу?

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** Хүүхэд ч байхгүй гэж үү?

**Эмэгтэй.** *(Хэсэг дуугүй байснаа)* За цамцаа өмсөөд үз.

**Эрэгтэй.** *(Гайхаж)* Болчих нь энэ үү?

**Эмэгтэй.** Та яасан яаруу хүн бэ. Би ханцуйгүйгээр дөнгөж шидэж торгоогоод байна. Өмс дөө.

*Эрэгтэй цамцыг өмсөөд их инээдтэй харагдана.*

*Эмэгтэй ажил хэрэгчээр шалгаж Эрэгтэйг нааш цааш эргүүлнэ.*

Битгий хөдөл ... өрөөсөн ханцуйг нь сүлбээр зүүгээр тогтооё. *(Ханцуйг тогтооно)* Гараа алдал ... эндээс жаахан хасах нь...

*Эмэгтэй даавуун дээр шохойгоор тэмдэглэнэ. Эрэгтэй тэвчээр алдан түүнийг тэвэрч авна.*

Та дахиад л нөгөөхөө эхлэв үү?

**Эрэгтэй.** Би цаашид тэвчихгүй нь ээ.

**Эмэгтэй.** Сайхан мэдээрэй, гарт минь дүүрэн сүлбээр зүү байна шүү.

**Эрэгтэй.** Намайг сонсооч.

**Эмэгтэй.** Хэрэггүй. Таныг би ёс журамтай хүн гэж бодсон юмсан.

**Эрэгтэй.** Миний хэлэх гээд байгаа юм ёс журманд ямарч хамаагүй.

**Эмэгтэй.** *(Тэврэлтээс мултарч)* За хэл л дээ.

**Эрэгтэй.** *(Өрөөсөн ханцуйтай цамцаа өмссөн хэвээр, ёслолын байдалтайгаар)* Би танд хайртай!

**Эмэгтэй.** Та чинь солиороо юу?

**Эрэгтэй.** Та үнэхээр үзэсгэлэнтэй, гайхамшигтай эзэгтэй, танд сайхан байшин, цэцэрлэг байна. Хамгийн гол нь танд аз жаргал алга. Магадгүй надтай цуг байвал танд дээр байх. Надад ч гэсэн адил. Өөрөөр хэлбэл та надтай гэрлээч!

**Эмэгтэй.** *(Ядарсан дуугаар)* Энэ л дутаж гэнэ дээ!

**Эрэгтэй.** Би танд таалагдахгүй байна гэж үү дээ?

**Эмэгтэй.** Та яг үнэнээр нь хэлээч, явсан хот болгондоо та гэрлэх санал тавьдаг уу?

**Эрэгтэй.** *(Гомдож)* Яалаа гэж хот болгонд байх билээ. Гэрлэлт гэдэг бол...

**Эмэгтэй.** Ингэхэд та чинь гэр бүлгүй юм уу?

**Эрэгтэй.** Би ингэж доромжлуулах юм хийгээгүй шүү.

**Эмэгтэй.** Тэгээд гэрлэж байгаагүй юм уу?

**Эрэгтэй.** Бараг үгүй. Дөнгөж гуравхан л удаа.

**Эмэгтэй.** Дөнгөж ий? Нэгэн зэрэг үү, дэс дараалаад уу?

**Эрэгтэй.** Танд магадгүй их олон юм шиг бодогдож байгаа байх...

**Эмэгтэй.** Би юу ч бодоогүй байна.

**Эрэгтэй.** Манайхан ч улирал болгонд гэрлэж байдаг юм.

**Эмэгтэй.** Энэ улиралд та намайг сонгохоор шийдээ юу?

**Эрэгтэй.** Таны тухайд бол өөр хэрэг ээ, та чинь циркийнх биш шүү дээ.

**Эмэгтэй.** Цамцаа тайлаад өг, дуусгах хэрэгтэй байна.

*Эрэгтэй цамцаа тайлна. Эмэгтэй оёдлын машины ард сууна. Зогсоц.*

Таны эхнэрүүд циркийнх байсан уу?

**Эрэгтэй.** *(Дурамжхан)* Тийм.

**Эмэгтэй.** Могой-хүүхэн, үзэсгэлэнт Стэлла?

**Эрэгтэй.** Үгүй ээ, миний анхны эхнэр амьтан сургагч байсан.

**Эмэгтэй.** Тэгээд ямар муужгай та хоёрын дундуур гүйчихсэн юм?

**Эрэгтэй.** Муужгай биш ээ, бар. Тэр намайг түүнтэй хардана – аймшигтай. Гэхдээ би дараа нь тэр бартай хэл амаа ололцсон л доо.

**Эмэгтэй.** Харин эхнэртэйгээ?

**Эрэгтэй.** Үгүй, чадаагүй. Та ойлгож байгаа биз дээ? Намайг сургах гэхэд би дургүй.

*Зогсоц*

**Эмэгтэй.** Тэгээд дараа нь?

**Эрэгтэй.** Дараагийнх нь агаарын гимнастикч бүсгүй байлаа. Тэр ч амьтан сургагчаас шал өөр байсан шүү.

*(Мөрөөдөнгүй)* уян хатан, зөөлөн, хөнгөн...

**Эмэгтэй.** *(Хөндийгөөр)* Та хоёр удсан уу?

**Эрэгтэй.** Маш богино. Гимнастикчийг хажуудаа байлгана гэдэг их хэцүү. Нэгээс нөгөөрүү нисчихдэг юм.

**Эмэгтэй.** Тэр одоо хаана байгаа юм?

**Эрэгтэй.** Мэдэхгүй ээ хаа нэгтээ л нисч яваа байх.

**Эмэгтэй.** *(Хэсэг дуугүй байснаа)* Дараачийнх нь хэн байсан бэ?

**Эрэгтэй.** Үл үзэгдэгч хүүхэн.

**Эмэгтэй.** Үл үзэгдэгч ээ?

**Эрэгтэй.** Тиймээ, тэр төрөлхийн илбэчин байсан. Үзүүлбэрүүд нь маш их амжилт олдог байлаа. Үзэгчдийн нүдэн дээр цаг, түрийвч, шүхэр агаарт замхарна. Дараа нь өөрөө ч замхарч алга болно.

**Эмэгтэй.** Сайхан хүүхэн байсан уу?

**Эрэгтэй.** Хүмүүс тэгж хэлдэг л юм. Харин би өөрийг нь бараг хараагүй л дээ.

**Эмэгтэй.** Энэнээс болоод та хоёр салсан юм уу?

**Эрэгтэй.** Үгүй ээ, надад илбэ нь таалагдаагүй юм.

**Эмэгтэй.** Энэнээс болж салж болно гэж үү дээ?

**Эрэгтэй.** Миний чемоданаас дарстай лонхнууд алга болоод байхыг би тэвчээгүй юм.

*Зогсоц*

**Эмэгтэй.** Тэгэхлээр та ганцаардлаа гэж гомдоллоод байх хэрэггүй л юм байна шүү дээ.

**Эрэгтэй.** Та дэмий л инээж байна даа. Олон хүүхэн гэдэг чинь нэг ч байхгүй л гэсэн үг. Тэгээд ч ер нь ийм гэр бүлийн амьдрал гэж юу байх билээ дээ. Гэрийн хоол гэж байхгүй, гэрийнхэнтэйгээ үдшийг хамт өнгөрөөнө гэж байхгүй. Дандаа л буудлаар хоноглоно.

*Түр чимээгүй болцгооно.*

**Эмэгтэй.** Та хүүхэдтэй юу?

**Эрэгтэй.** Хүүтэй. Гайхалтай хүү бий, би тэрэнд их хайртай.

**Эмэгтэй.** Тэр хаана байгаа юм?

**Эрэгтэй.** Мэдэхгүй ээ, хаа нэгтэй ээжтэйгээ л байгаа. Тэгээд ч насанд хүрчихсэн л дээ.

**Эмэгтэй.** *(Бодолхийлж)* Сонин юм. Яагаад та чинь ингэж азгүйтдэг байна аа?

**Эрэгтэй.** Мэдэхгүй юм аа. Үгүй яахав, нэг бол цирк, нэг бол гэр бүл гэсэн хууль байдаг юм. Нэгэн зэрэг тэнэмэл амьдралаар эсвэл гэр бүлийн амьдралаар амьдарч болохгүй шүү дээ. Яахав нэг тохиолдолд тогтвортой гэр бүл байж болох л юм.

**Эмэгтэй.** Ямар?

**Эрэгтэй.** Эхнэр нөхөр хоёрын номер ижил байвал.

**Эмэгтэй.** *(Ойлгож ядан)* Уучлаарай, ямар номер гэж?

**Эрэгтэй.** Ойлгож байна уу? Эхнэр нөхөр хоёр нэг үзүүлбэрт цуг ажиллах ёстой. Өөрөөр тэдэнд хөтөлбөрт цуг байх боломж байхгүй. Улирал дууслаа, баяртай. Нөхөр нь баруун зүг, нөгөө нь өөр зүгт. Акробатынхан, гимнастикийнхан, эсвэл морьтонгууд хосоороо юмуу багаараа ажилладаг болохоор боломжтой. Эсвэл хөгжимчид. Нөхөр нь нэхмэлийн зүүгээр, эхнэр нь хөрөөгөөр, хүүхэд нь шар айрагны лонхоор хөгжимдөөд л. Эд яагаад гэр бүл байж болохгүй гэж. Тэр ч байтугай илбэчид хүртэл өөртөө туслагч авч шидэт саваа бариулаад үзэгчдийг татахын тулд бариу трико өмсгөөд тоглож болно.

**Эмэгтэй.** Та ч туслагч эмэгтэй авч болох л байсан шүү дээ.

**Эрэгтэй.** Би ч шаардаж байсан л даа, гэхдээ хүчтэнд эмэгтэй хүн ямар хэрэг болох билээ. Ямар жонглёрчинд бөмбөлөг шидэж өгч байгаатай адил биш. “Арвыг ч болтугай ав, гэхдээ өөрөө л хариуцаарай” гэдэг юм. Та хэлээч, одоо цагт хэн л өөрийнхөө мөнгөөр тийм эмэгтэйг хажуудаа ажиллуулж байх вэ дээ.

**Эмэгтэй.** Танд бага цалин өгдөг гэж үү?

**Эрэгтэй.** Тэгэлгүй яахав! *(Гэнэт санаж)* Үгүй яахав, тийм ч бага биш л дээ. Гэхдээ намайг хүнд жинд ажилладаг гэдгийг огт бодолцдоггүй юм. Хэргийн гол нь намайг хоёр дугаар зэргийн бүрэлдэхүүнд оруулчихсанд байгаа юм. Мэдээж санамсаргүйгээр л дээ. Тэгээд ч түр зуур. Би мэдээж дээд зэргийн бүрэлдэхүүнд дасчихсан хүн, та ойлгож байгаа биз дээ? Хуйвалдаан, нууц явуулга...

**Эмэгтэй.** Циркд хуйвалдаан байдаг гэж үү?

**Эрэгтэй.** Ээ дээ, та хөшигний цаадахь манай ертөнцийг мэддэг ч болоосой. Тэд надад дээд зэргийн бүрэлдэхүүнд та арай хөгшдөж байна гэж хэлж зүрхэлж байгаа юм даа. Одоо намайг шүү дээ.

**Эмэгтэй.** Үнэхээр тийм үү?

**Эрэгтэй.** Би мэдээж тийм залуу биш л дээ. Гэхдээ ямарч хүүхдийн дор орохгүй. Хамгийн гол нь миний алдар нэр. Одоо ч цирк өөрийгөө жүжигчин гэсэн янз бүрийн ичгүүргүй залуучууд, ямар нэгэн юмны аваргуудаар дүүрч дээ.

**Эмэгтэй.** Та чинь аварга байгаагүй юм уу?

**Эрэгтэй.** Байлгүй яахав, хэзээ гээч? Тэгээд ч одоо хэн энэ тухай санах билээ дээ. *(Дуугаа намсаж)* Танд нэг нууц хэлэхэд “БҮХ ОДОД” гэдэг айлчлан тоглолтын бүрэлдэхүүн бүрдүүлж байгаа. Харин надад нилээн нөлөөтэй танил бий шүү...

**Эмэгтэй.** Тэгээд юу гэж?

**Эрэгтэй.** *(Нууцханаар)* Магадгүй намайг оруулчих ч юм билүү? Цахилгаан явуулна гэж амласан. *(Бодолхийлснээ)* За, худлаа л хэлээ биз дээ.

**Эмэгтэй.** Та циркд тийм ч дуртай биш юм аа даа?

**Эрэгтэй.** Тиймээ, би үзэн яддаг. Яагаад хүмүүс үзэх гэж очоод байдгийг нь ч ойлгодоггүй. Би л байсан бол тийшээ зүглэх ч үгүй. Дан хууран мэхлэлт, тэнэгүүдэд болон хүүхдэд л таарсан үзүүлбэрүүд.

**Эмэгтэй.** Та туухай, туйвангуудаасаа залхаагүй юу?

**Эрэгтэй.** Залхалгүй яахав, яг үнэндээ бол энэ хэнд ч хэрэггүй нэгэн хэвийн тэнэг зүйл байхгүй юу. Акробатчин жишээлбэл үсрэх, эргэлдэхээ яаж ийгээд өөрчилчихөж болно. Би ч мэдээж хөтөлбөрөө туйванг гараараа, хөлөөрөө, хүзүүгээрээ, шүдээрээ, тэр ч байтугай уучлаарай, нуруугаараа өргөх зэргээр олон төрлийн болгох гэж үзсэн л дээ. Тэгээд байхад л надаас өөр илүүг хүсээд байдаг юм.

**Эмэгтэй.** Та циркийг ингэж үзэн яддаг юм бол яагаад тэнд ажиллаад байдаг юм бэ?

**Эрэгтэй.** Бүгдийг хаях юмсан гэж боддог л юм, болохгүй байна. Тэгээд ч надад өөр чадах юм байх биш. Цагтаа суралцаж, инженер больё гэж бодож л байлаа, бүтээгүй. Театрт ч орж байлаа. Тэнд ч харин энэ луйварчдыг бодвол жинхэнэ урлаг байдаг юм шүү.

**Эмэгтэй.** Тэгээд юу болсон бэ?

**Эрэгтэй.** Авъяасгүй гээд намайг аваагүй ээ. Тэгээд л туйвантай ноцолдож байна даа ... *(түр дуугүй болсноо)* би өөрийнхөө тухай чалчсаар байгаад таныг залхааж байх шиг байна. Та харин өөрийнхөө тухай яриач.

**Эмэгтэй.** Та харж байгаа биз дээ, надад ярих юм юу байх вэ дээ – гэр, цэцэрлэг, гал тогоо, оёдол ... өдөр бүр нэг хэвийн. Таныхаас огт өөр.

**Эрэгтэй.** Энэ чинь сайхан шүү дээ.

**Эмэгтэй.** Заримдаа мэдээж хаашаа ч юм явмаар л байдаг юм.

**Эрэгтэй.** Огт хэрэггүй, би замд явахыг үзэн яддаг. Энэ хараал идсэн галт тэрэгнүүдэд дандаа салхи сийгэж байдаг юм. Гэтэл би чинь нурууны өвчтэй хүн.

**Эмэгтэй.** Гэхдээ ертөнцтэй танилцах хэрэгтэй шүү дээ.

**Эрэгтэй.** Огт хэрэггүй. Жинхэнэ ертөнц гэдэг чинь өөрийн гэр, цэцэрлэг харин бусад нь зочид буудал.

**Эмэгтэй.** Энэ жинхэнэ ертөнцөд чинь заримдаа маш уйтгартай байдаг юм.

*Чимээгүй.*

**Эрэгтэй.** Ингэхэд та яагаад ганцаараа амьдардагаа хэлээч?

**Эмэгтэй.** Ийм л байна.

**Эрэгтэй.** Та чинь яагаад дахиад нөхөрт гарч болдоггүй юм? Эрчүүдийг үзэн яддаг юм уу?

**Эмэгтэй.** Эрчүүдийг үзэн яддаг ч нөхөрт гарахыг хүсдэггүй гэж худлаа ярихгүй ээ. Гэхдээ хэнтэй суух вэ гэдэг асуудал байна.

**Эрэгтэй.** Танд хүсч байсан хүн байхгүй гэж үү?

**Эмэгтэй.** Байсаан, заримд нь миний байшин, заримд нь оёх, хоол хийх, заримд нь бүр миний гадаад байдал л таалагддаг байсан.

**Эрэгтэй.** Тэр харав уу?

**Эмэгтэй.** Гэхдээ, хэн нь ч намайг аз жаргалтай байлгахыг боддоггүй байсан. Ойлгож байна уу намайг!

**Эрэгтэй.** Гэхдээ танд, чин сэтгэлээсээ хандаж байсан хүн таарч байгаагүй гэж үү?

**Эмэгтэй.** Байсаан, гэхдээ энэ нь улам дор байсан. Намайг дөнгөж хайрлаж, найдаж эхэлж байхад л бүх юм дуусчихдаг.

**Эрэгтэй.** Яагаад?

**Эмэгтэй.** Мэдэхгүй, янз бүрийн байдал үүсч, ямар нэг юм өөрчлөгдөөд... ерөнхийдөө намайг дандаа хаячихдаг юм.

**Эрэгтэй.** Хаячихдаг аа? Таныг уу? Харин та л өөрөө хаядаг байлгүй дээ.

**Эмэгтэй.** Үгүй ээ, би хэзээ ч хаяж байгаагүй, дандаа л хаягддаг.

**Эрэгтэй.** Яагаад тэр вэ?

**Эмэгтэй.** Мэдэхгүй ээ, би тийм л азгүй хүн дээ.

**Эрэгтэй.** Бас дээр нь миний энэ тэнэг санал! Би бодолгүй дуугарчихаж.

**Эмэгтэй.** Та бүр харамсаад эхэлчихсэн үү?

**Эрэгтэй.** Яалаа гэж, гэхдээ над шиг ховдог, орон гэргүй ийм нөхөр танд хэрэгтэй гэж үү? Бод л доо тан шиг эмэгтэйд би тохирно гэж үү?

**Эмэгтэй.** Та намайг огт мэдэхгүй байна.

**Эрэгтэй.** Таныг ямар эзэгтэй болохыг ойлгохын тулд хийсэн шөлнөөс чинь ганц л халбагадахад болно. Би үнэнээсээ ярьж байна шүү.

**Эмэгтэй.** Эхнэр гэдэг чинь зөвхөн тогооч биш шүү дээ.

**Эрэгтэй.** Тэгэлгүй яахав, та намайг өнгөрсөн шөнийг мартсан гэж бодож байна уу? Харин тийм юм байгаагүй юм шиг дүр битгий үзүүл. Бид хоёр хоёулаа сайн санаж байгаа. Хэрэвээ би таныг гайхамшигтай эмэгтэй гэж байвал та тийм л гэсэн үг.

**Эмэгтэй.** (*Ичингүйрэн инээмсэглэж*) Та ч сайхан ярих юм аа.

**Эрэгтэй.** Би бодож байгаагаа л ярьж байна. Та бол миний удаан эрсэн хүн яг мөн байна. Яг үнэндээ би эрэлээ зогсоочихлоо, яагаад гэвэл та байна. Харин би гэж мэргэжил ч үгүй хүн байж байдаг!

**Эмэгтэй.** Яагаад байхгүй гэж? Та чинь тамирчин, циркийн жүжигчин. Танд бүгд алга ташдаг.

**Эрэгтэй.** Үгүй дээ. Алга ташилт нижигнээд өнгөрсөн, би ч амжилтын хувиа хүртсэн. Циркээс салах цаг минь боллоо.

**Эмэгтэй.** Танд нэг газар байгаад байх уйтгартай байх болно доо.

**Эрэгтэй.** Та галзуураа юу! Би энэ цыганы амьдралыг хүртэхээрээ л нэг боллоо. Нэг газарт амьдрахын тулд би газар малтагч ч юмуу, гудамж цэвэрлэгчээр ажиллахад ч бэлэн байна. Гэртээ харьж ирээд л эелдэг хонгор эхнэртэйгээ оройн хоолоо цуг идээд л... энэнээс хүн залхана гэж үү?

**Эмэгтэй.** Мэдэхгүй юм даа.

**Эрэгтэй.** Надтай гэрлээч! Тэгээд та мэдэх болно.

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** Гэрлэхгүй юмуу?

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** Яагаад?

*Эмэгтэй мөрөө хавчина*

Танд би таалагдахгүй байна уу?

**Эмэгтэй.** Үгүй ээ, яалаа гэж...

**Эрэгтэй.** Тэгвэл болоо биш үү?

*Эмэгтэй хариулахгүй. Эрэгтэй түүнрүү дөхөж очно.*

(*Зөөлнөөр*) Айх хэрэггүй ээ, харж л байгаарай, бид хоёр сайхан амьдрана аа. Одоо та дахиад хэзээ ч ганцаардахгүй.

**Эмэгтэй.** (*Огцом*) Болиоч дээ.

*Зогсоц. Эмэгтэй оёдлоо үргэлжлүүлнэ. Эрэгтэй урвайж цонхруу очно. Бороо, салхи шуугина.*

**Эрэгтэй.** Бороо орсоор л байдаг.

*Эмэгтэй үл хариулна. Эрэгтэй санаа алдаад өрөөрүүгээ орно. Эмэгтэй оёдлоо зогсоож аажуухан босч толь руу дөхөж бодлогоширон тольдоно. Эрэгтэй гартаа цув барин орж ирнэ.*

**Эмэгтэй.** Та хаачих гэв?

**Эрэгтэй.** Мэдэхгүй ... цирк рүү.

**Эмэгтэй.** (*Эрэгтэйрүү дөхснөө алхаагаа удаашируулснаа зориг муутайхан тэвэрнэ*) Сонсооч, бид нээрэн...оролдоод үзэх хэрэгтэй ч юмуу?

**Эрэгтэй.** (*Хөшиж, гартаа цуваа барьсан хэвээр*) Юу оролдоод үзэх гэж?

**Эмэгтэй.** (*Сэтгэл нь догдолж*) Намайг тийм гэж битгий бодоорой... би ... огтхон ч ууртай хатсан талх биш... би ердийн л эмэгтэй...хайрлаж дурламаар байна. Би шал өөр болно оо, хараарай, ганцхан намайг битгий л хаяарай, за юу? (*Нулимсаа барьж ядан*) Би чамайг маш ихээр хайрлах болно... Ингэж зовоогүй хүн бол ойлгохгүй шүү дээ... харин би ... чи харах болно оо. (*Уйлна*)

**Эрэгтэй.** (*Цуваа алдаж, энхрийлэн тэвэрнэ*) Тайвшир, хэрэггүй ээ... бүх юм сайхан болно ... суу

*Эмэгтэйг суулгаж өөрөө өөр сандал авч зэрэгцэж суун мөрөөр нь тэвэрнэ. Эмэгтэй бага зэрэг тайвширна.*

Одоо надад ойлгогдохоор хэл дээ, чи зөвшөөрч байна уу?

**Эмэгтэй.** (*Нулимстай инээж*) Бурхан минь, тэгэлгүй яах вэ. Чи яасан юм ойлгодоггүй юм бэ.

**Эрэгтэй.** Тэгэхлээр би чиний нөхөр болж байх шив. Нэг л эвгүй байх чинь.

**Эмэгтэй.** Хоёулаа бүртгүүлэхгүй байсан ч болно оо.

**Эрэгтэй.** Заавал бүртгүүлнэ, тэгэхгүй бол чи бодлоо өөрчилчих ч юм билүү.

**Эмэгтэй.** *(Аальгүйгээр)* Харин чи л өөрчлөх байх даа.

**Эрэгтэй.** Хэзээ ч үгүй.

*Зогсоц. Эрэгтэй Эмэгтэй хоёр тэврэлдэн сууна.*

**Эмэгтэй.** Чи юун тухай бодож байна?

**Эрэгтэй.** Хоёулаа яаж амьдрах тухай.

**Эмэгтэй.** Тэгээд юу гэж бодов?

**Эрэгтэй.** Хамгийн эхлээд циркээ бүр мөсөн хаяж өөр ажил олно.

**Эмэгтэй.** Ажил олохоо бүү яар. Чи эхлээд амрах хэрэгтэй. Тэр хооронд би чамайг хооллож хувцаслана...

**Эрэгтэй.** Ийм ховдгийг хооллох ч ...

**Эмэгтэй.** Чи огт ховдог биш, зүгээр л гэрийн хоол үгүүлсэн хүн.

**Эрэгтэй.** Би юу ч хийхгүй дээшээ харж хэвтээд, харин чи хоёр хүний төлөө нуруугаа бөхийтөл зүтгэх болж байна уу? Үгүй ээ, тэгж таарахгүй. Чиний амьдрал одоо шал өөр болно гэдгийг би чамд амлъя. Нэг дүгээрт, ямар ч хүнд өрөө хөлслүүлэхгүй. Гүйцээ. Хүнд ажлыг чи ор тас март. Чамаар би өд ч өргүүлэхгүй. Яваандаа оёхоо ч болино биз.

**Эмэгтэй.** Тэгээд бид юугаараа амьдрах болж байна аа?

**Эрэгтэй.** Би ачигч хийнээ. Хоёр хүний цалин өгөх байх.

**Эмэгтэй.** Үгүй ээ, чамаар ачигч хийлгүүлэхгүй. Биеэ бодох цаг чинь болсон. Тэрний оронд би юмаа оёж байя.

**Эрэгтэй.** Оёдлын ажлаа болих хэрэгтэй гэж би хэлсэн шүү дээ.

**Эмэгтэй.** За харж л байя.

**Эрэгтэй.** Хараад байх юм байхгүй, би зөвшөөрөхгүй байна. Гүйцээ.

**Эмэгтэй.** Зөвшөөрөхгүй гэнэ ээ? Хэрэвээ би үгэнд чинь орохгүй байвал яахав?

**Эрэгтэй.** Тэгээд үзээрэй л дээ.

**Эмэгтэй.** Намайг хүн захирахад би дургүй шүү.

**Эрэгтэй.** *(Ширүүнээр)* Дахиад нэг л үг дуугарвал наад машиныг чинь цонхоор чулуудчихана шүү!

**Эмэгтэй.** *(Чимээгүй байснаа инээж)* Сонсооч бид хоёр аль хэдийнэ хэрэлдэж эхэлж байх шиг байна.

**Эрэгтэй.** Тийм үү? *(Гэмшиж)* Уучлаарай, юу болоод байгааг би өөрөө ч ойлгохгүй байна.

**Эмэгтэй.** Гомдох хэрэггүй дээ, би оёх дуртай.

**Эрэгтэй.** Өөрийнхөө л юмыг оёж байгаарай.

**Эмэгтэй.** Бидний

**Эрэгтэй.** За яахав, бидний. Эхлээд би чиний цэцэрлэгийг янзална аа. Бүгдийг цэвэрлэж, газрыг нь хагалж ...*(Цонхоор зааж)* тэр юун шилэн бүхээг вэ?

**Эмэгтэй.** *(Инээж)* Хүлэмж. Өөрөө хийсэн юм. Инээдтэй байгаа биз, чи тэнд багтах ч үгүй.

**Эрэгтэй.** Тэнд чи юу ургуулдаг юм? Өргөст хэмх үү?

**Эмэгтэй.** Цахирмаа цэцэг.

**Эрэгтэй.** Хөөх, өөрийн цахирмаа цэцэг ий? Янзтай.

**Эмэгтэй.** Ургуулахад маш хэцүү байдаг юм. Тэнд хоёрхон л цэцэг байгаа. Би ургуулах гэж олон жил оролдсон шүү.

**Эрэгтэй.** Би чамд дотор нь заан ч орсон багтахаар хүлэмж барьж өгнө өө. Бас байшинг чинь сууринаас нь дээвэр хүртэл засварлана.

**Эмэгтэй.** Бидний байшинг.

**Эрэгтэй.** Тиймээ, бидний, манай байшин! *(Мөрөөдөн)* орой тагтан дээр сууж, цайгаа уугаад л... сайхаан! Төсөөлж байна уу? Өөрийн байшин гэдэг ч!

**Эмэгтэй.** *(Инээж)* Төсөөлөхгүй л байна шүү.

**Эрэгтэй.** Би хэзээ ч нэг газар тогтож амьдарч үзээгүй.

**Эмэгтэй.** Тэгэхлээр чи гэрт суухаас дороо уйдаах юм байна даа. *(Бодолхийлж)* Чамайг уйдаад байвал хоёулаа аялалаар явж болно, тийм ээ?

**Эрэгтэй.** *(Айж)* Үгүй яалаа гэж!.. Үгүй яахав, хэрэв чамайг хүсвэл...

**Эмэгтэй.** Бид адилхан юм аа.

**Эрэгтэй.** Тэгвэл гэртээ л сууцгаана даа. Чамайг уйдаахгүйн тулд амралтын өдрөөр зочид урина аа, хоёул аа.

**Эмэгтэй.** Би ч ер нь их зожиг амьдралтай хүн.

**Эрэгтэй.** Харин бид нийтэч амьдрана аа. Яахав намайг ямар гайхамшигтай эхнэртэйг бүгд харцгааг.

**Эмэгтэй.** *(Инээж)* Бурхан минь, үгүй чи чинь ямар онгиороо хүн бэ! *(Огло харайн)* Байзаарай, би одоохон! *(Гадагш гүйн гарна)*

**Эрэгтэй.** *(Араас ухасхийж)* Хаачих нь вэ? бороо орж байна шүү дээ!

*Гэвч эмэгтэй аль хэдийнэ алга болсон байна. Эрэгтэй яахаа мэдэхээ байж, ганцаараа үлдэнэ. Гэхдээ тэрний ганцаардал удаан үргэлжлэхгүй. Шалба норсон ч аз жаргалаар дүүрэн Эмэгтэй хоёр гоё тод өнгийн цэцэг барьсаар орж ирнэ.*

**Эмэгтэй.** *(Цэцгээ сарвайж)* Май, энийг чамд.

**Эрэгтэй.** *(Гайхан биширч)* Энэ... энэ чинь, Цахирмаа юу?

**Эмэгтэй.** Тийм ээ.

**Эрэгтэй.** Ийм ховор цэцгийг...Чи чинь өчнөөн жил ургуулсан шүү дээ...

**Эмэгтэй.** Чамд зориулж

**Эрэгтэй.** Солиотой байх аа!

**Эмэгтэй.** *(Инээж)* Солиотой байлгүй яахав! Бидний шийдвэр солиорол биш гэж үү? *(Инээдээ зогсоож)* Ийм өдөр амьдралд ганцхан л тохиолдоно. Гэтэл чи цэцгэнд харамсч байдаг.

**Эрэгтэй.** Чамаас гайхамшигтай шив шинэхэн агаарын үнэр ханхалж байна!

**Эмэгтэй.** Бороо, цэцэрлэгийн үнэр.

**Эрэгтэй.** Чиний даашинз үнэхээр сайхан юм аа.

**Эмэгтэй.** Зүгээр л энгийн даашинз шүү дээ.

**Эрэгтэй.** Би энгийн зүйлд л дуртай. Хэтэрхий чамин, тод юмнууд циркд л байдаг юм.

**Эмэгтэй.** Хэлсэн чинь сайн боллоо. Гоёлын даа шинэ маань тийм тод, эрэн цоохор юм байгаа.

**Эрэгтэй.** Үгүй яахав, цоохороо ч гэсэн өмснө л биз.

**Эмэгтэй.** Үгүй ээ, одоо бол үгүй шүү.

*Зогсоц.*

**Эрэгтэй.** Чи юу бодож байна?

**Эмэгтэй.** Чамайг яаж тогтоох байх вэ л гэж бодож байна.

**Эрэгтэй.** (Мөрөөр нь тэвэрч) Тэнэгхэн минь дээ.

*Зогсоц.*

**Эмэгтэй.** Чи надад өөрийнхөө дадал зуршил, сонирхдог бүх зүйлээ ярих хэрэгтэй.

**Эрэгтэй.** Чи ч бас өөрийнхийгөө.

**Эмэгтэй.** Би өөрийнхөө сурснаар биш, чиний сурснаар л амьдарна аа. (*Баяртайгаар*) Хараач, бороо зогсчихлоо!

**Эрэгтэй.** (*Цонхруу дөхөж*) Ямар сайхан юм бэ? Юу ч ярьсан, өөрийн цэцэрлэг гэдэг бол... за за, чи ч ойлгохгүй л дээ.

*Эмэгтэй инээнэ.*

Би ч гэсэн цэцэг тарина. Үгүй ээ, үгүй, юу ... улаан лооль, гоньд, тарьсан нь дээр юм байна. Шинэхэн ногоог талбайгаасаа шууд тасдаад идэлгүй лав зуун жил болсон байх.

**Эмэгтэй.** (*Инээж*) Магадгүй хоёулаа торой тэжээсэн ч болно ш дээ?

**Эрэгтэй.** Торойгоор яах гэсэн юм? Өөрсдөө хүүхэдтэй болж өсгөсөн нь дээр байх аа.

**Эмэгтэй.** (*Инээхээ больж*) Юу гэнээ? Нээрэн үү?

**Эрэгтэй.** Тэгэлгүй яахав, гэхдээ чи хүсэхгүй байгаа бол ... уг нь бид хоёр охинтой болвол сайн сан. Хөөрхөн, жижигхэн ... би охинтойгоо зугаалаад л ...

**Эмэгтэй.** Гэхдээ энэ чинь ... нөгөө ...

**Эрэгтэй.** Юу гэж?

**Эмэгтэй.** Энэ боломжгүй ээ.

**Эрэгтэй.** Яагаад боломжгүй гэж... Чи хүсэхгүй байгаа юм уу?

**Эмэгтэй.** Миний хувьд ... одоо оройтсон байх аа.

**Эрэгтэй.** Ингэж ярихаа боль л доо. Чи минь яг л ид насан дээрээ байна шүү дээ.

**Эмэгтэй.** Чи тэгж бодож байна гэж үү?

**Эрэгтэй.** Бодоод байх юу байх вэ!

**Эмэгтэй.** Нээрэн, үзээд алдвал яадаг бол?

**Эрэгтэй.** Үзээд алдвал гэнэ шүү, чи бүр гурвыг ч гаргана.

**Эмэгтэй.** (*Инээж, царай нь улайн*) Ганцаас л эхлье л дээ.

**Эрэгтэй.** (*Эмэгтэйг тэвэрч*) Чи зөвшөөрч байгаа юм уу?

**Эмэгтэй.** (*Мөрөнд нь нүүрээ нааж*) Би бүр найдлага тасарчихаад байсан юм.

**Эрэгтэй.** (*Чангаар тэвэрч*) Тэгвэл хойшлуулаад яахав!

**Эмэгтэй.** Тийм ээ, юугаа хүлээх вэ!

*Хонх дуугарна.*

**Эрэгтэй.** Хэн юм бол?

**Эмэгтэй.** Мэдэхгүй. (*Хаалга руу явах гэнэ*)

**Эрэгтэй.** (*Тогтоон барьж*) Битгий онгойлго.

**Эмэгтэй.** Чам дээр хүн ирж байгаа ч юм билүү?

**Эрэгтэй.** (*Ойлгож ядан*) Хэн байдаг билээ?

**Эмэгтэй.** Мэдэхгүй ээ... Хэн нэгэн нь циркээс ирж байгаа юм болов уу? ...(*инээж*) Могой-Хүүхэн!

**Эрэгтэй.** Үгүй ээ, ямарч тийм могой байгаагүй, чи мэдэж байгаа шүү дээ.

*Хонх дахин дуугарна.*

**Эмэгтэй.** Ямар ч байсан онгойлгоё.

*Гарч явна. Эрэгтэй алх хадаас, модон савааг барьж сандлын хөлийг засахаар завдна. Эмэгтэй орж ирнэ.*

Чамд цахилгаан мэдээ ирж!

*Эрэгтэй үл итгэн гартаа цахилгааныг эргүүлж байснаа задлан уншиж, баярлан хөөрч толгой дээгүүрээ сэгсрэн эргүүлнэ.*

**Эрэгтэй.** Ирчихлээ, ямар ч байсан явуулсан байна!

**Эмэгтэй.** Наад дээр чинь юу гэсэн байна?

**Эрэгтэй.** (*Ёслол төгөлдөр*) Май, Унш!

**Эмэгтэй.** (*Цахилгааныг уншаад*) Чи баярлаад байгаа юм уу?

**Эрэгтэй.** Тэгэлгүй яахав! Гэхдээ намайг хасах гэж зүтгэж байсан хүн байсан юм шүү! Гэлээ ч гэсэн хуучин бууны хугархай бууж өгөхгүй шүү. (*Цахилгааныг уншин*) Яахав, ганц л улиралд урьсан байна, гэхдээ манайд дандаа л ингэж байдаг юм. (*Өөрөөрөө бахархан*) Надгүйгээр тэд яаж ч чадахгүй гэж би мэдээд байсан юм аа!

**Эмэгтэй.** Гэхдээ чи ямар нэг хуйвалдаан, гадуурхлаас айгаад байгаагүй биш үү?

**Эрэгтэй.** Жинхэнэ алдар нэрийг гадуурхаад хаа холдох вэ дээ. Цирк гэдэг чинь нэрэн дээр тогтож байдаг эд. Харин миний нэр үү? Ямарч тод одоос би бүдэг биш шүү!

**Эмэгтэй.** Хэзээ ир гэсэн байна?

**Эрэгтэй.** (*Дахиад цахилгаан руу харж*) Өнөөдөр. (*Цахилгааныг түлхэж*) Гэхдээ би хаашаа ч явахгүй.

**Эмэгтэй.** Явахгүй гэж үү?

**Эрэгтэй.** Гүйцээ! Миний тэнэмэл амьдрал дууслаа! Бид хоёр тохирсон биз дээ. Эсвэл чи надаас залхчихсан уу?

**Эмэгтэй.** (*Эрэгтэйг тэвэрч*) Үгүй дээ хонгор минь, амжаагүй байна.

**Эрэгтэй.** Тэгвэл бид эндээс хөдлөхгүй. Алив би сандлаа дуусгаадхая, чи цай чанаач.

**Эмэгтэй.** Бялуу?

**Эрэгтэй.** Тэгэлгүй яахав, дараа нь би тэр цоргыг засна аа. Чиний цорго гоожоод байна.

**Эмэгтэй.** “Чиний” биш, “манай”

**Эрэгтэй.** Тийм ээ, “манай”

*Эмэгтэй цахилгаан тулган дээр юм хийж, Эрэгтэй сандал засна.*

Захирал энэ цахилгааныг үзээд царай нь ямар болох нь нүдэнд харагдаж байна.

**Эмэгтэй.** Чамд ямар хамаа байсан юм – чи чинь тэгээд явах гээд байгаа юм уу?

**Эрэгтэй.** Циркийнхэн ч бужигнана даа! Бүрэлдэхүүний тал нь атаархаж үхнэ дээ!

**Эмэгтэй.** Цай буцалчихлаа, наадах аа орхичих.

**Эрэгтэй.** Дуусчихлаа даа, за ямар болж вэ? (*Дээр нь сууж шалгана*)

**Эмэгтэй.** Маш сайн байна.

**Эрэгтэй.** Над шиг жин ихтэй хүний тавилга бөх байх ёстой!

*Эмэгтэй ширээн дээр цай, бялуу тавина. Эрэгтэй цай ууна.*

**Эмэгтэй.** Ааг нь хэтэрчихээгүй биз? Чиний ямар цайнд дуртайг мэдэхгүй юм.

**Эрэгтэй.** (*Тоомжиргүй*) Яг таарсан байна. Оддын дунд өөр хэн хэн байх бол гэдэг ч сонирхол татаж ...

**Эмэгтэй.** Уу л даа хөрлөө.

**Эрэгтэй.** Силетти – г бас урьсан гэсэн байх шүү.

**Эмэгтэй.** (*Бялуутай тавгийг дөхүүлж*) Май, идээрэй.

**Эрэгтэй.** Ингэхэд цалинг хоёр дахин нэмэгдүүлж, дээр нь бас шагналын мөнгө гэж өгнө гэсэн шүү.

**Эмэгтэй.** Бялуу ямар байна?

**Эрэгтэй.** Маш амттай байна. (*Гэнэт нудрагаа зангидан хамаг юм доргитол ширээ цохино*)

**Эмэгтэй.** Яасан бэ?

**Эрэгтэй.** (*Сэтгэл нь хөдөлж*) Арай миний оронд тэд Бугаевыг авчих юм биш байгаа?

**Эмэгтэй.** Энэнд чи юундаа санаа зовоод байгаа юм бэ?

**Эрэгтэй.** Тэгэлгүй яахав, тэрний булчин нь булчин биш хөвөн л гэсэн үг. Тэрний бүх алдар нэр ганц сайхан сахалтай нь л холбоотой.

**Эмэгтэй.** Тайвшир л даа. Чиний оронд өөр хүн дуудахгүй байлгүй дээ.

**Эрэгтэй.** Үгүй, тийм юм гэж байхгүй. Баатаргүй цирк бол цирк биш!

*Эрэгтэй босч, сэтгэл тавгүй холхиж, цонхны дэргэд зогсоно.*

(*Уйтгартайгаар*) Бороо орж байна.

**Эмэгтэй.** Дахиад уу?

**Эрэгтэй.** Дахиад.

*Зогсоц. Эмэгтэй гал тогооноос гарч яваад сонингийн хайчилбар авчирч Эрэгтэйд өгнө.*

Энэ юу вэ?

**Эмэгтэй.** Галт тэрэгний цагийн хуваарь.

**Эрэгтэй.** Яах гэж?

*Эмэгтэй дугаралгүй, юм оёхоор сууна.*

Би хаашаа ч явах гээгүй байна.

*Эмэгтэй дуу гарахгүй.*

Чи яагаад цай уухгүй байгаа юм?

**Эмэгтэй.** Цаг алга аа.

**Эрэгтэй.** Миний бодоход ... чамд байшин, цэцэрлэг, тавилга байхад надад юу ч алга.... Энэ бүх бэлэн юман

дээр ирээд суучихна гэхэд нэг л эвгүй ... чи яагаад бүр дуугүй болчихов оо?

**Эмэгтэй.** Би сонсож байна аа,

**Эрэгтэй.** Гэтэл тэнд надад хоёр дахин их цалин бас шагналын мөнгө өгөх гэж байдаг.

**Эмэгтэй.** Энэ тухай чи ярьсан шүү дээ.

**Эрэгтэй.** Тэгэхлээр нэгхэн сезон үзээд алдвал яадаг бол? Чи юу гэж бодож байна?

*Эмэгтэй үл хариулна.*

Харамсалтай нь чи даанч циркэд ажиллаж чадахгүй юм.

*Эмэгтэй үл хариулна.*

Үгүй ингэхэд чи чинь хэн ч хийчихэж чадахаар энгийн юм хийж чадах юм биш биз?

**Эмэгтэй.** Жишээлбэл юу?

**Эрэгтэй.** Үгүй ядаж, гар дээрээ явах ч юм уу, эсвэл ганц дугуйтай унадаг дугуй унах ч юм уу?

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** Чи арай хаанаас ч юм кенгуру олж чадах юм биш биз?

**Эмэгтэй.** Үгүй.

**Эрэгтэй.** Их харамсалтай байна. Туузан дээрх кенгуру гэж бараг бэлэн үзүүлбэр байдаг юм.

**Эмэгтэй.** (*Ухасхийн Эрэгтэйг тэвэрч*) Хонгор минь, намайг цуг аваад яваач! Туузаараа хүлээд ч хамаагүй аваад яваач. Би тэр кенгуру чинь больё, тэгэх үү?!

**Эрэгтэй.** (*Итгэл алдарч*) Чи байшин, цэцэрлэгээ яах болж байна?

**Эмэгтэй.** Бүгдийг хаяна аа. Чамд би туузгүйгээр хүлэгдчихээд байна, ойлгож байна уу?

**Эрэгтэй.** Чи даан ч тэсэхэд бэрх, тэр олон ...

**Эмэгтэй.** Тэгвэл чи л явахаа больчих л доо. Дэлхийгээр нэг тэнэхээ болиод үлдчих. Өөрийгөө тэр зовлонт цирктэй хүлсэн туузыг тасдаад чөлөөл.

**Эрэгтэй.** Би заавал үлдэнэ ээ. Гэхдээ ийм боломж...

**Эмэгтэй.** (*Эрэгтэйгээс холдож*) Уучлаарай, би юу ярьж байгаагаа өөрөө ч мэдэхээ болилоо. Чи магадгүй явсан нь ч дээр юм уу.

**Эрэгтэй.** Чи нээрээ тэгж бодож байна уу?

**Эмэгтэй.** Тийм ээ, тэгэлгүй яахав. Ядаж эрэгцүүлэх боломж гаргахын тулд.

**Эрэгтэй.** Харин тийм. Энэ бүгдийг эрэгцүүлэх хэрэгтэй ... Чи нээрэн тэгж бодож байна уу?

*Эмэгтэй үл хариулна. Эрэгтэй цагийн хуваарийг шалгана.*

**Эмэгтэй.** Галт тэрэг гурван цагийн дараа явна.

**Эрэгтэй.** (*Шийдмэг бус*) Тэгвэл би явдаг юм билүү?

**Эмэгтэй.** Ийм эрт үү?

**Эрэгтэй.** Замаараа циркээр орж энэ тухай мэдэгдэх хэрэгтэй байна.

*Эмэгтэй дуугүй байна, Эрэгтэй босно.*

**Эмэгтэй.** Жаахан хүлээгээрэй! (*Цамцыг гүйцээж оёно*) Өмс дөө.

**Эрэгтэй.** Өө, бүр бэлэн болчихсон уу?

*Эрэгтэй цамцыг өмсөнө. Эмэгтэй товчоо товчилоход нь тусална. Эрэгтэй толинд харна.*

Маш сайхан цамц болсон байна.

**Эмэгтэй.** Дараа нь хэн нэгнийг гуйгаад индүүдүүлчихээрэй, би амжсангүй.

**Эрэгтэй.** Баярлалаа. Индүүдлэггүй байсан ч сайхан байна. *(Эмэгтэйг татаж)* Бүх зүйлд чинь маш их баярлалаа. Чи их ухаантай, халамжтай, үзэсгэлэнтэй... Чиний дэргэд би ч зүгээр л тэжээвэр тэмээ юм аа. Чи ийм амьтнаар яах вэ дээ.

**Эмэгтэй.** Тийм ээ, хэрэггүй.

*Гараас нь мултрахыг оролдоход Эрэгтэй тавихгүй.*

**Эрэгтэй.** Харж л байгаарай, би удахгүй ирнэ. Цаг хугацаа өнгөрснийг мэдээ ч үгүй байхад чинь би хүрээд ирнэ, тэгээд бид хэзээ ч салахгүй.

**Эмэгтэй.** Тийм ээ

**Эрэгтэй.** Ойлгож байна уу? Миний хамгийн сүүлчийн улирал! Тэгээд л би бүгдийг хаяна. Нээрэн шүү, бүр мөсөн хаяна.

**Эмэгтэй.** Тиймээ.

**Эрэгтэй.** Би чамайг алган дээрээ бөмбөрүүлнэ ээ, зөндөө гоё гоё юм авч өгнө!

**Эмэгтэй.** Яв даа.

**Эрэгтэй.** Би чамд захиа бичнэ ээ.

**Эмэгтэй.** Яв даа.

*Эрэгтэй уруу царайлан хувцасаа өмсөж, тухайнуудаа авна.*

**Эрэгтэй.** Баяртай.

*Эмэгтэй хариу хэлэхгүй. Эрэгтэй удаанаар гарч явна. Эмэгтэй үлдэнэ. Цонхны цаанаас бороо салхины чимээ сонсогдно. Эрэгтэй норчихсон, өрөвдөлтэй царайлан эргэж орж ирнэ. Эмэгтэй түүний хөлийн чимээг сонсоод огцом эргэж харна.*

*(Гэмшилтэйгээр мушийж)* Би байна аа.

**Эмэгтэй.** Юу хэрэгтэй болоо вэ?

**Эрэгтэй.** *(Санаа зовниж)* би мөнгөний талаар л ...

**Эмэгтэй.** Өө нээрэн тийм, чи чинь мөнгөө төлөхөө мартсан байна шүү дээ.

**Эрэгтэй.** Үгүй ээ, мартаагүй... Ойлгож байна уу? Цалин нөгөөдөр бууна, гэтэл би өнөөдөр явах болчихлоо... Дараа нь би шилжүүлчихэж болох уу?

**Эмэгтэй.** Боломжтой болохоороо шилжүүлээрэй.

**Эрэгтэй.** Харин чи надад тасалбар авах мөнгө өгөөч? Ойлгож байгаа биз дээ? Цалин нөгөөдөр бууна...

*Эмэгтэй мөнгө гаргаж Эрэгтэйд өгнө.*

**Эмэгтэй.** Энэ хүрэх үү?

**Эрэгтэй.** Хүрнэ ээ, баярлалаа.

*Эрэгтэй явна. Эмэгтэй хоосорсон гал тогоогоо удаанаар тойруулан харна. Оёдлын машины ойролцоо цамцны даавууны өөдөснүүд. Буланд зэрэгцсэн хоёр сандал, ширээн дээр хоёр аяга, цэцгийн саванд хоёр тод өнгийн цэцэг. Эмэгтэй өөдсүүдийг түүж зуух руу шиед сандлуудыг салгаж тавиад цэцгүүдийг хаяж ширээн дээрээс нэг аягыг нь авна. Аяга гараас нь*

*алдагдаж газар унаж хагарна. Эмэгтэй хагархайнуудыг түүхээр доошоо суух боловч суусан чигээрээ хоосон зүйл рүү гөлөрч хөдөлгөөнгүй болно.*

**Төгсөв**